

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 05 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар: Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа хуралдаж 7 асуудал хэлэлцэж, 7 асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр уламжлав.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 39 өргөдөл бичгээр хүлээн авч, 23 өргөдлийг шийдвэрлэж, 16 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, мөн аймгийн Засаг даргын Тамгын газарт 7 өргөдөл бичгээр хүлээн авч, 5 өргөдлийг шийдвэрлэж, 2 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 2 өргөдөл хүлээн авч шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Иргэдээс 7 сувгаар мэдээлэл хүлээн авах 7043-1111 төвд 2 сувгаар 36 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 35, биечлэн 1 иргэн санал, гомдол ирүүлснээс гомдол 18, санал хүсэлт 17, шүүмжлэл 1 тус тус бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 33 иргэний санал хүсэлт, гомдолд хариу өгч шийдвэрлэж шийдвэрлэлт 91.7 хувьтай байна. Орчны эрүүл ахуйн чиглэлээр 6, хууль эрх зүй 3, эрүүл мэнд 3, боловсрол 6, бусад 18 санал хүсэлт хүлээн авсан байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдлийг “Саналын хайрцгаар өргөдөл хүлээн авах журам”-ын дагуу энэ сард санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын 1111 төвд ирсэн 21 санал хүсэлт хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж 20 санал хүсэлтийн хариуг илгээж, 1 санал хүсэлт шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 5 дугаар сарын санхүүжилтийг олгож, цалин хөлс, тогтмол зардал, зарим зайлшгүй гарах зардлуудыг санхүүжүүллээ.

Төсвийн, орон нутгийн өмчийн болон аж ахуйн нэгж байгууллагууд, төсөл, сангуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тэнцлийг хүлээн авсан дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар илтгэл бэлтгэн, Засаг даргын зөвлөлийн хэлэлцүүлж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд өргөн барилаа.

Сангийн яамнаас төсвийн тодотгол хийж, орон нутгийн 2017 оны тодотгосон төсөв боловсруулж, батлуулахад баримтлах зарчмын талаар албан бичиг ирснийг аймгийн ЗДТГ-ын болон хэлтсийн дарга нарт олшруулан хүргүүлж, сум, байгууллагын саналыг авч төсвийн тодотголын төслийг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар тус тус хэлэлцүүлжээ.

Орон нутгийн төсвийн тодотголын материалыг хэвлүүлж, аймгийн ИТХ, сум, байгууллагын удирдлагуудад гарын авлага болгохоор тараан мэдээллээр хангаж ажиллав.

Мэргэшсэн нягтлан бодогч болон нийт санхүүчдийн жилийн уулзалт-өдөрлөгийг “Хямралыг хяналтаар хязгаарлъя” сэдвийн дор 5 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж нийт 140 гаруй хүн хамрагдсан ба өдөрлөгийн арга хэмжээнд аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Ховд аймаг дахь Төрийн аудитын газар, Санхүүгийн хяналт аудитын алба, Татварын хэлтэс, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс тус тусын мэдээлэл хийж, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар танилцуулж санал бодлоо солилцов.

Жаргалант сумын төсөвт байгууллага болох цэцэрлэг, сургуулийн санхүүгийн үйл ажиллагаатай танилцан, үр дүнд хяналт, үнэлгээ хийж, зөвлөмж өгөх, санхүүгийн

холбогдолтой хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн ажиллав.

Аймгийн Татварын хэлтэс, Санхүүгийн хяналт аудитын алба, Статистикийн хэлтэс хамтран иргэдийн төвлөрөл ихтэй Баруун бүсийн төв захад нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, танин мэдэхүйн “АХА” тэмцээнийг зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд оролцсон иргэд, хувиараа бизнес эрхлэгчдийн дунд азтан шалгаруулж, нийт 400 гаруй иргэнд гарын авлага тарааж, тэдний санал хүсэлтийг сонсож, сонирхсон асуултанд холбогдох албан тушаалтнууд хариулт өгч ажиллалаа.

Албан журмын даатгалын албатай хамтран даатгалын салбаруудын дарга, менежерүүдтэй уулзалт хийж, хууль, журам зөрчсөн үйл ажиллагаа явуулахыг зогсоох арга хэмжээ авлаа.

Мэргэшсэн нягтлан бодогчдын шалгалтанд 9 нягтлан бодогч оролцож, 2 нягтлан бодогч мэргэшсэнгийн эрх авлаа.

Төсвийн суурь орлогод 2448,4 сая төгрөг орж төлөвлөгөө 24,0 сая төгрөгөөр давж биелсэн байна. Үүнээс татварын орлогод 2255,3 сая төгрөг орж төлөвлөгөө 88,5 сая төгрөгөөр давж, хөрөнгийн орлогод 15,0 сая төгрөг орж, төлөвлөгөө 11,2 сая төгрөгөөр, татварын бус орлогод 178,1 сая төгрөг орж төлөвлөгөө 53,5 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Дээд шатны төсвөөс авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлэг, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэгийг бүрэн авав.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогод 663,7 сая төгрөг оруулахаас 460,9 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 202,8 сая төгрөгөөр дутуу буюу 69,4 хувиар, аймагт төвлөрүүлэх орлогод 2533,1 сая төгрөг оруулахаас 2099,3 мянган төгрөг оруулж төлөвлөгөөг 433,8 сая төгрөгөөр дутуу буюу 82,9 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн нийт урсгал зарлага 17916,8 сая төгрөгт хүрч төсөвлөснөөс 3045,6 сая төгрөгөөр хэмнэлттэй гарсан урьдчилсан дүнтэй байна.

Энэ улиралд төсөв эдийн засгийн ангиллаар болон төсвийн захирагчаар хэтрээгүй байна. Энэ нь төсвийн орлого бүрдүүлэлт хангалтгүй байгаа болон аймаг, сумдын төрийн сангаас хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа зэргээс шалтгаалж байна.

Орон нутгийн төсвийн өр 492,8 сая , авлага 133,1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс өр 310,7 сая төгрөгөөр буурч, авлага 54,7 сая төгрөгөөр өссөн байна.

Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд: Сумдын захирамж, тушаал хянах тухай албан бичиг, хуваарийн дагуу Ховд, Эрдэнэбүрэн, Манхан, Дарви, Мөнххайрхан сумдын захирамж, тушаалыг хууль тогтоомжийн хэрэглээ, үндэслэл, архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр, хамаарал бүхий этгээдтэй холбоотой шийдвэр гаргасан эсэх талаар хянан дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлэв.

Хэлтсийн хурлыг 7 удаа хийж, 5 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч ажиллав. “Тайван-Амгалан-Ховдчууд” хөтөлбөрийн төслийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлуулж сум, байгууллагуудад хүргүүлэв. Хууль сахиулах байгууллагуудтай хамтран “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж салбарын хүрээнд хийгдсэн мэдээ мэдээлэл, ажил үйлчилгээг сурталчлан ажиллав. Мөн Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран Захиргааны ерөнхий хуулийн ойлголт” сэдэвт сургалт зохион байгуулав. Сургалтанд сум, байгууллагын 200 гаруй албан тушаалтнууд хамрагдаж хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэв. Засгийн газрын 5 тогтоолд өөрчлөлт хөдөлгөөн оруулж ажиллав.

Архивын тасгаас 45 хүнд захирамж, тушаалын лавлагааг олгосон бөгөөд 1958-2007 оны 17 хөмрөгийн 19 дансны 277 ширхэг хадгаламжийн нэгжийн 82798 хуудас материалыг цахим системд шивж оруулав.

Цагдаагийн газар: 2017 оны 05 дугаар сарын 24-ний байдлаар 33 гэмт хэрэг бүртгэгдсэн ба гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл бусдын бие махбодид гэмтэл учруулах 9, хулгайлах 13, үүнээс иргэдийн өмчийн хулгай 10, малын хулгай 3, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг 6, бусдын эд хөрөнгө завших 1, бусдын эд хөрөнгө санаатай устгах 1, танхайрах 1, бусад гэмт хэрэг 2 тус тус бүртгэгдсэн байна.

Цагдаагийн газар тайлант хугацаанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 353 гомдол мэдээлэл хүлээн авснаас гэмт хэрэг 83 буюу 23.5 хувийг, 270 буюу 76.5 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эзэлж байна. Бүртгэгдсэн гомдол мэдээллийг төрлөөр нь ангилан үзвэл хулгайлах 48, бусдын бие махбодид гэмтэл учруулах 15, хүний амь нас хохирсон 2, хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн 12, танхайрсан 2, худалдаа үйлчилгээний журам зөрчсөн 3, согтуу тээврийн хэрэгсэл жолоодсон 75, хүчиндэх 1, зам тээврийн осол 23, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 1, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон 8, зам тээврийн осол 5 гомдол мэдээлэл тус тус бүртгэгдсэн байна.

Зөрчил гаргасан 113 хүнийг албадан саатуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, жижгээр танхайрсан зөрчилд 29 хүнийг 7-30 хоногийн хугацаатайгаар баривчлуулж, 40 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, зөрчил гаргасан 1285 хүнийг 47.899.000 төгрөгөөр торгох арга хэмжээ авлаа.

Хуулийн байгууллагуудтай хамтран “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион явуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үзүүлэн, гарын авлага материал дэлгэн байрлуулж, санамж, сэрэмжлүүлэг тараав.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй аймгийн удирдлагууд оролцсон уулзалтанд оролцон аймгийн эрүү, хэв журмын нөхцөл байдал болон хүүхдийн хүмүүжлийн талаар мэдээ мэдээлэл хийж, иргэдийн сонирхсон асуултанд хариулт өглөө.

Улсын хэмжээнд насанд хүрээгүй хүмүүс ахуйн хэрэглээний газ үнэрлэж мансуурах асуудал нэмэгдсэнтэй холбогдуулан энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим сайтуудад сэрэмжлүүлэг мэдээллийг нийтлүүлэн, аж ахуйн нэгж, дэлгүүрүүдийг 18 насанд хүрээгүй хүнд ахуйн хэрэглээний газ худалдаалахыг хориглох хууль эрх зүйн акт гаргуулах саналыг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлээд байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх аяны хүрээнд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллагын үүрэг оролцоо”, “Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлье” сэдвээр 6 байгууллагын 186 албан тушаалтанд сургалт хэлэлцүүлгийг зохион явуулсан. Ховд Их сургуулийн оюутнуудад “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” болон “Хүчирхийллийн тухай ойлголт” сэдвээр, математик, байгалийн ухаан, гадаад хэлний гүнзгийрүүлсэн лицей ахлах сургуулийн 63 сурагчдад “Гэмт хэргийн хор уршиг”, “Үе тэнгийнхний дарамтаас сэргийлэх нь”, Жаргалант сумын 12 багийн 110 иргэнийг хамруулан “Хууль дүрэм-бидний амьдралд” сэдвээр, Прокурорын газар, ШШГА-тай хамтран “Гэмт хэрэг, түүний хор уршиг, аливаа хорт зуршлаас сэргийлэх нь” сургалтыг зохион байгуулж оролцогчдын сонирхсон асуултанд хариулт өгч, гарын авлага, материал тараав.

Төрийн байгууллагыг “Олон нийтийн эргүүл”-ээр ажиллуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Жаргалант сумын Засаг даргын 2017 оны А/96 дугаар захирамж гаргуулсан бөгөөд энэ хугацаанд 25 байгууллагын 67 ажилтан эргүүлээр ажиллав.

Булган сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсээс тус сумын ГХУСАЗСЗ, төр захиргааны байгууллагатай хамтарч сум хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн тодорхой хэсгүүдэд хяналтын камер байршуулан, Цагдаагийн хэлтсийн жижүүрийн бүрэлдэхүүн нэгдсэн хяналтаар ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга болон Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүний ивээл дор Дэлхийн Зөн Ховд Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 17 сумдын эцэг, эхийн төлөөлөл нийт 160 иргэнийг хамруулан “Шинэ зууны эцэг эхчүүд” гэр бүлийн зөвлөгөөнийг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан.

Шүүхийн шинжилгээний алба: Шүүхийн шинжилгээний албанд хандаж 41 албан бичиг, шинжилгээ хийлгүүлэх 90 тогтоол, захирамж ирүүлснийг хүлээн авч бүртгэн тухай бүр нь шийдвэрлэж 23 албан бичиг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 4 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийг 53 хүнд, химийн шинжилгээ 8, биологийн шинжилгээ 7, бэлгийн холбогдолтой 4 шинжилгээ, криминалистикийн 14 шинжилгээг хийж, нийт 90 дүгнэлт гаргаж, алсын дуудлаганд криминалистикийн шинжээч, шинжээч эмч, туслах ажилтан нар 9 удаа явж үүрэгт ажлаа биелүүлэв.

Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 92 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 67 ширхэг мөр, гутлын мөр 37, тээврийн хэрэгслийн мөр 39, бусад ул мөр, 89 эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 86, 27 гарын мөр тус тус авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийв.

Албанаас гарч баталгаажсан шинжилгээ, дүгнэлтүүдийг тухай бүр нь цахимжууллаа.

Ажилд орохыг хүссэн 1 өргөдөл ирүүлснийг хүлээн авч хариуг хуулийн хугацаанд өгч шийдвэрлэв. Алба хаагчдын сахилга, ёс зүйтэй холбоотой мэдээлэл ирээгүй байна.

2017 онд улсын төсвөөс нийт 187,519,000 төгрөгийн төсөв батлагдсанаас 2017 оны эхний 5 сарын байдлаар цалин хөлс нэмэгдэл урамшилд 66,329,000, нийгмийн даатгалд 2,375,500, хангамж бараа материалын зардалд 3,083,000, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд нийт 4,479,000 төгрөгийг тус тус зориулалтын дагуу батлагдсан төсвийн хүрээнд зарцуулав.

Төлбөрт үйлчилгээний орлогод 1,394,000 төгрөг төвлөрүүлсэн болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба: Тус алба нь нийт 64 албан хаагчийн орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаас 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар хүний нөөц сургалт мэдээлэл хариуцсан мэргэжилтэн 1, хуяглан хүргэх офицер 1, шийдвэр гүйцэтгэгч 2, дэд бөгөөд гүйцэтгэх ажил, харуул хамгаалалт хариуцсан дарга 1, нийт 5 албан хаагч томилогдоогүй 59 алба хаагчтай ажиллаж байна.

Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, цэрэгжилт, жагсаалч байдлыг хангах, ажлын цаг ашиглалт, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор ажил эхлэх, дуусах цагуудад нэгтгэн жагсааж бүртгэн, ажлын цаг ашиглалтанд хяналт тавиж ажиллаж ирсний зэрэгцээ 7 хоногийн Баасан гарагт нийт бүрэлдэхүүнийг хичээл сургалт жагсаалын бэлтгэл, хувцасны үзлэгт хамруулан, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулан ажиллаж байна. Алтай багийн нэрэмжит сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай орлцов.

Тус албаны шинээр баригдах Цагдан хорих байр болон конторын барилгын ажил эхэлсэнтэй холбогдуулан бусдад төлөх өр төлбөртэй нэр бүхий 15 ялтанг барилгын туслах ажилтнаар ажиллууж байна. Барилгын ажил 45 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Цагдаагийн газартай хамтран ажиллах гэрээний дагуу хуваарьт өдрүүдэд тус албанаас 4 алба хаагч эргүүлийн үүрэг гүйцэтгэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан мод тарих өдрөөр тус албанаас өөрийн хамгаалалтын бүсэд байрлах ойн зурваст нийт алба хаагчид 300 ширхэг мод тарьсан.

Хорих ангийн харуул хамгаалалтыг” Хорих ангийн харуул хамгаалалт болон ялтанд хяналт тавих журам”-ын дагуу албаны даргын тушаалаар онцгой учралын үед ажиллах төлөвлөгөөг сар бүр шинэчлэн батлуулж, алба хаагчдад танилцуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж байна. Болзошгүй ажиллагааны үед ашиглагдах тээврийн хэрэгслийн бэлэн байдал, гал унтраах багаж хэрэгсэл, нөөц цахилгаан үүсгүүр, гар чийдэн, гэрлийн шил, бэлэн байдлын түлшний талон зэргийг тогтмол шалган бүртгэлээр хүлээлцэн алба хаагчдад өдөр бүр бичгээр үүрэг даалгавар өгч биелэлтэнд хяналт тавилаа.

Ангийн байрлалаас 800 м-т байрлах малын хэсэгт 1 хянагчийн хяналтанд нэр бүхий 3 ялтныг ажиллуулж, эргэн шалгах төлөвлөгөөний дагуу шалган нэмэлт үүрэг даалгавраар тогтмол хангав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба - Хорих 457 дугаар ангийн үйл ажиллагаа хууль журмын дагуу хэвийн явагдаж байгаа бөгөөд ялтан, хоригдогч нарын дундаас ямар нэгэн гэмт хэрэг зөрчилгүй тайван байгаа болно.

Улсын бүртгэлийн хэлтэс: Энэ сард нийт 5713 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас Иргэний бүртгэлийн чиглэлээр 4928, аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд 260 ба шилжин ирсэн иргэд 21, шилжин явсан иргэд 29 иргэн, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн 210, гадаад паспорт олголт болон сунгалт 430, иргэний үнэмлэх шинээр олгосон 168, сунгалт 215, дахин олгосон 77, иргэний бүртгэлийн лавлагаа 413 олгож, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн 3365 бүртгэлийг хийв.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 663, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 105 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж ажилласан.

Иргэдээс нийт 17 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс 9 хуулийн хугацаанд шийдвэрлэж, 8 өргөдлийн хугацаа болоогүй байна.

Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсрол, соёлын чиглэлээр: Аймгийн Боловсрол, соёл урлагийн газар нь тайлант сард 36 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж ажиллаа.

Жаргалант сумын “Хүүхэд харах үйлчилгээ”-ний 10 газар, Дарви сумын сургуулийн өмнөх боловсролын байгууллага, хувийн хэвшлийн 13 цэцэрлэгийн сургалтын орчин болоод хөгжүүлэх үйл ажиллагаатай танилцаж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн, бага боловсролын сургалтад мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ, судалгаа хийж тулгамдсан асуудлын талаар мэдээлэл бэлтгэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд хүргүүлэв.

Бүгд найрамдах Солонгос улсын соёл, спорт, аялал жуулчлалын яамны дэргэдэх Олон улсын соёлын солилцооны Солонгосын сан Монгол улсад 2012 оноос эхлэн нийслэлийн 3, Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгийн 3 сургууль нийт 6 сургуульд “Баярлалаа бяцхан номын сан” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, хөтөлбөрийн хүрээнд шинээр хэвлэгдэн гарч буй номоор хангах, номын сангийн анги танхимыг тохижуулах, техник тоног төхөөрөмжөөр хангах ажлуудыг амжилттай сайн гүйцэтгэсэн туршлагад тулгуурлан 2017 онд аймгийн Прогресс, 7 дугаар сургууль, Булган сумын 1 дүгээр сургуульд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр сонгон ажиллав.

Суурь болон бүрэн дунд боловсролын стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийх зорилгоор Үнэлгээний төвөөс зохион байгуулдаг улсын шалгалтад комисс ажиллаж улсын шалгалтын явц болон хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллээр ханган ажиллаж байна.

Олон улсын эко сургуулийн “Хүрэл гэрэгэ”-г Зэрэг, Манхан, Ховд, Эрдэнэбүрэн, Жаргалант сумын 1,3 дугаар нийт 6 сургуулиудын 2 төлөөлөлтэй хамтран гардан авах ёслолд оролцлоо. Мөн дэлхий нийтийн тогтвортой хөгжил, Монгол улсын ногоон хөгжлийг дэмжигч тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаанд суурилсан олон улсын эко сургууль хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа үр дүнгээ хэлэлцэх, цаашид мөнгөн гэрэгэ, ногоон тугийн болзол шалгуур, шаардлагатай танилцах, ололт амжилт, тэргүүн туршлагаа солилцох зорилгоор эко сургуулийн ахисан шатны сургалтад хамрагдав.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг бага ангийн 15 багш Улаанбаатар хотын 116, 55, 60, 63, 118 дугаар сургуулиудын багш нарын туршлага судлан харилцан туршлагаа солилцож, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын арга зүйчид хамрагдаж мэргэжлээ дээшлүүлсэн. Аймгийн “Чадварлаг багш” дэд хөтөлбөрийн 2.2.1 Багшийн багаар ажиллах, бие даан суралцах чадварыг хөгжүүлэх, 2.2.2. Багшийн өөрийн нөөц бололцоогоо нээн илрүүлэх, харилцааны ур чадварыг нэмэгдүүлэх, 2.2.3. Багшийн судлан шинжлэх, илтгэх, нөлөөлөх чадварыг нэмэгдүүлэх зорилтуудын хүрээнд Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн байгалийн ухааны багш нарын дунд “Багшийн хөгжил-хичээлийн судалгаа” аяныг 2017 оны 03 дугаар сарын 14 ээс 05 дугаар сарын 14-ны хооронд зохион байгуулсан.Тус аянд Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн Физикийн 15 багш, “Цахилгаан гүйдлийн ажил чадал”, “Гэрлийн хугарлыг судлах” сэдэвт хичээлүүдийн бэлтгэл судалгаа хийлээ.

Норвегийн тусламжийн байгууллагын хүүхдийн эрх төслөөс Боловсрол соёл урлагийн газрын мэргэжилтэн, үйлчилгээний ажилчдад “Харилцаа”, “Багийн ажил”, “Үзэл бодлоо илэрхийлэх соёл” сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан.

Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарт багшлах эрх олгуулах 67 багшийн материал, нөхөн олгох-3 нийт 70 багшийн материалыг багшийн мэргэжил дээшлүүлэх институтын цахим сургалтын албаны мэргэжилтэн Батхүүд хянуулан бичиг хэрэгт архивын нэгж бүрдүүлэн 2 боть, материалыг хүлээлгэн өглөө.

Улсын техник технологийн 21-р олимпиадад 12 хүний бүрэлпэхүүнтэй баг оролцож, Дарви сумын багш Ж.Баттөмөр 3 дугаар байр, 12 жилийн 1-р сургуулийн сурагч Д.Болорэрдэнэ тусгай байранд орлоо. Улсын физикийн олимпиадын хороо, Физик боловсрол төрийн бус байгууллага, МУБИС-аас хамтран зохион байгуулдаг “Багийн олимпиад-2017” олимпиадад Цаст алтай цогцолбор сургуулийн Ч.Туул багштай 8 дугаар ангийн багийн сурагчид хүрэл медаль, Прогресс сургуулийн физикийн багш Э.Ганчимэг, Д.Оюунсүрэн багштай 7,8 дугаар ангийн багийн сурагчид, мөнгөн медалын болзол хангасан.

Улсын физикийн 30 дугаар олимпиадын 3-ын даваанд Ховд аймгаас 3 багш 2 суралцагчийн хамтаар оролцож, Цаст-Алтай цогцолбор сургуулийн 12 дугаар ангийн сурагч О.Доржсамбуу тусгай байр буюу “Уран бодогч” сурагчаар шалгарлаа.

Элсэлтийн ерөнхий шалгалтад физикийн хичээлээр шалгалт өгөх 12 дугаар ангийн сурагчдаас сурагч өөртөө болон багш сурагчдаа урьдчилсан байдлаар үнэлж, ЭЭШ-ийн бэлтгэлд дүн шинжилгээ хийх зорилгоор “Сорил-2”-ийг зохион байгуулсан. Сорилд ЕБС-ийн 206 суралцагч хамрагдлаа. Жаргалант сумын ЕБС-ийн “Сорил-2”-ийг 1 дүгээр сургууль дээр нэгдсэн журмаар зохион байгуулсан.

Мөн УИХ-ын гишүүн, ХЗДХ-ийн сайд, Ховд аймгийн Нутгийн зөвлөлийн дарга С.Бямбацогтын нэрэмжит багийн, олон төрөлт хичээлийн “Оюуны их сорилго” олимпиад 2017 оны 5 сарын 7-8-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа.

Тус олимпиадад Ховд аймгийн Ерөнхий боловсролын 24 сургуулийн 120 сурагч, багш нарынхаа хамт оролцон Математик, Физик, Сэтгэх чадвар, Нийгмийн тухай мэдлэг, Англи хэл гэсэн 5 хичээлээр мэдлэг оюунаа сорин өрсөлдөв.

“Оюуны их сорилго” олимпиадад Жаргалант сумын Прогресс сургуулийн баг 69,44 оноогоор тэргүүн байранд шалгарч "Батламж", "Цом", 1 500 000 төгрөгөөр, 12 жилийн 1-р сургуулийн баг 64,76 оноогоор 2-р байранд, "Батламж", "Цом", 1 000 000 төгрөгөөр, Цаст-Алтай цогцолбор сургуулийн баг 63,85 оноогоор 3-р байранд шалгарч "Батламж", "Цом", 800 000 төгрөгөөр шагнууллаа. Мөн 12 жилийн 3-р дунд сургуулийн баг 60,95 оноогоор, 12 жилийн 6-р сургуулийн баг 54,58 оноогоор тусгай байранд шалгарлаа.

"Оюуны их сорилго" багийн олон төрөлт олимпиадад сурагчидаа сайн бэлтгэсэн 5 багшийг мөн шалгаруулан шагнаж урамшууллаа. Тухайлбал: Прогресс сургуулийн Англи хэлний багш н.Лхамзаяа, 12 жилийн 1-р сургуулийн Математикийн багш /Сэтгэх чадвар/ Ч.Байгалмаа, Цаст-Алтай цогцолбор сургуулийн Нийгмийн ухааны багш Х.Нямсүрэн, Булган сумын 1-р сургуулийн Математикийн багш Ш.Цэвэлмаа, Жаргалант сумын 12 жилийн 6-р сургуулийн Физикийн багш Б.Дэлгэрмаа нар шалгарч "Батламж" медаль, 200 000 төгрөгөөр шагнууллаа. Харин хамгийн зохион байгуулалт сайтай оролцсон сургуулиар Жаргалант сумын 12 жилийн 7-р сургуулийн баг хамт олон шалгарсан байна.

Монгол бичгийн унших, бичих үндсэн чадварыг ангийн сурагч бүрд олгох, багшийн үйл ажиллагаагаар шавь нарыг нь, шавь нарынх нь чадвараар багшийг нь алдаршуулж сурталчлах зорилгоор монгол бичгийн сургалт судалгааны “Ертөнц төв”-өөс зохион байгуулж буй “Үндэсний өв соёлоо түгээгч, тээгч-2017 ” улсын уралдааныг Ховд аймгийн 2017 оны 05 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

2016-2017 оны хичээлийн жилд Ховд аймаг энэхүү уралдаанд сургууль бүрийг хамруулах зорилго тавин ажиллаж, уралдааны бэлтгэл болгон мэргэжилтэн Д.Олонбаяр “Хичээнгүй бичиг”- 150 ширхэг, “Уншлагын сурах бичиг”- 230 ширхэг, “Оюуны мэлмий” ном 550 ширхэгийг Ү.Ариунболд багшаар дамжуулан худалдан авч сургуулиудад хүргэсэн. Мөн багш нар хувиараа эдгээр номуудыг худалдан авч бэлтгэлээ хийлээ.

Багш нар өөрсдийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг гарган 9 сараас 5 сар хүртэл хичээнгүйлэн ажилласан.

Уралдааны 2 дахь шатны шалгаруулалтын удирдамжийг бүх сумуудад хүргүүлэн зааврыг дагуу сургуулиуд комисс гарган зохион байгууллаа.

Төрийн шагналт Ардын жүжигчин Ж.Чулууны нэрэмжит Алтан гадас одонт Хөгжимт Драмын Театр нь 2017 оны уран бүтээлийн төлөвлөгөөнд тусгагдсан дагуу Францын алдарт жүжгийн зохиолч Клод Маньегийн “Миний нууц” инээдмийн драмын жүжгийг тоглож, нийт 600 гаруй үзэгч үзэж сонирхолоо. Уг жүжгийг Цэцэг, Мянгад, Манхан суманд тоглосон.

2017 оны 05 дугаар сарын байдлаар дараах үйл ажиллагаанд үйлдвэр захиргаа анги үйлчилэгээ үзүүлэн ажиллаж, нийт гадны 16 үйл ажиллагаа явуулан 5600 гаруй иргэдэд үйлчиллээ.

Аймгийн музей нээлттэй хаалганы өдөрлөгөө 05 дугаар сарын 3-ний өдөр зохион байгуулж, Өв соёлын хүрээлэнд гэр үзэсгэлэн гаргаж, Жаргалант сумын 12 багийн иргэд болон Цаст-Алтай сургуулийн 100 гаруй иргэд, сурагчдад үнэ төлбөргүй үзүүлж үйлчлэв.

Ховд аймгийн Мянгад сумын Урд улаан үнээт уулнаас 2015 онд, Мөнххайрхан сумын нутаг Үзүүр гялан хэмээх газраас 2016 онд олдсон хоёр хадны оршуулгаас гарсан

олдворуудаар Монголын Үндэсний түүхийн музейд “Хадан гэрийн соёл” үзэсгэлэн зохион байгууллаа.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Олон улсын Музейн баярын өдрийг тохиолдуулан аймгийн Музейгээс эрдэм шинжилгээний бага хурал, хүрэл зэвсгийн үзэсгэлэн зохион байгуулав.

Дэлхийн байгаль хамгаалах өдрийг тохиолдуулан Алтайн нүүдэлчид төрийн бус байгууллагатай хамтран Ховд аймгийн Манхан сумын үл хөдлөх түүх, соёлын дурсгалтай танилцах аялал зохион байгуулав. Энэхүү аялалд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, хувиараа бизнес эрхлэгчид нийлсэн 15 хүн оролцлоо.

Нийтийн номын сан нь 2017 оны 5 дугаар сард 257 байнгын уншигч, 2816 ирцэд, 4103 ном сонин сэтгүүл олгож үйлчиллээ. Номын сангийн тасаг танхмиуд нь 5 дугаар сард хийх ажлын төлөвлөгөө гаргаж, түүнийхээ дагуу ажилаа зохион явуулж ажиллаа. Аймгийн Засаг даргын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ч.Уранчимэг харьяа салбарынхаа байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан, салбар чиглэл бүрээрээ хамтран ажиллаж нийгэм, эрүүл мэнд, соёлын салбарт харьяалагдах байгууллагуудын удирдлагууд Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэсийн үйл ажиллагаатай танилцан, туршлага солилцох зөвлөлгөөнд оролцож санал бодлоо хуваалцлаа.

Политехник коллежийн оюутны байрны оюутнуудад эрдэм шинжилгээний тасгийн номын санч ном солилцоогоор 286 ном өгч, байрны оюутнуудад олгож ажиллан, “Бичиг үсгийн баяр”-ыг Ард Аюушийн талбайд “Нээлттэй хаалганы өдөр” болгон зохион байгууллаа. Бичиг үсгийн баярын үйл ажиллагаанд “Монгол бичиг бидний бахархал ” эсээ бичлэгийн уралдаан, “Монгол калиграф” бичлэгийн уралдаан, “Уран үзэгтэн” хичээнгүй бичгийн уралдаан, “ Монгол бичгээр хэн алдаагүй хурдан унших вэ” зэрэг уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулж шалгаруулан шагнаж урамшууллаа. Энэхүү үйл ажиллагаанд давхардсан тоогоор 280 гаруй оролцогчид хамрагдлаа.

Жаргалант сумын 3, 8-р цэцэрлэгт “Үлгэрийн цаг” үйл ажиллагааг Жаргалант сумын 2-р сургуулийн Хүүхэлдэйн театрын сурагчдтай хамтран зохин байгуулж, 3-р цэцэрлэгийн ахлах бүлгийн 25 бяцхан хүүхдүүдийг “Хүүхдийн номын өргөө” нд ирж “Үл мэдэх” танхимын үйл ажиллагаатай танилцаж үлгэрийн ном уншиж ярилцлаа. Мөн Жаргалант сумын 3-р сургуулийн 3^б ангийн 30 сурагчдад тасаг танхимын үйл ажиллагааг танилцуулж ном уншлага зохин байгуулж уншсан номын сэдвээр АХА тэмцээн зохин явуулав.

Америкийн боловсролын талаар Улаанбаатар хотын Education USE хөтөлбөрийн ажилтан Баярцогт ирж ЕБС-ийн сургуулиуд болон Ховд их сургуулийн болон, Политехник коллежийн оюутнуудад, Америкийн төв дээр Олон нийтэд мөн мэдээлэл хийлээ.

Эрүүл мэндийн чиглэлээр: “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагааг 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд албан тоот хүргүүлэн бэлтгэл ажлыг ханган ажиллах арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн энэ үеэр элэгний В, С вирусийн эсрэг эмийг эм ханган нийлүүлэх байгууллагууд ард иргэдэд танилцууллаа.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр “Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн зорилго, 2017 онд 40-65 насны хүмүүс, 2018 онд 15-39 насны хүмүүс хамрагдахаар болсон тухай, В гепатитын вакциныг В вирус илэрээгүй 40-65 насны хүмүүст үнэгүй хийх, үнэгүй шинжилгээнд хамрагдах тухай мэдээллийг олон нийтэд хүргэлээ.

Сумдын багийн бага эмч нарын сургалт зохион байгуулж нийт 35 хүнийг хамруулж багийн эмч нарын мэдлэгийг нэмэгдүүлсэн.

“Шинэ зууны эцэг эхчүүд” аймгийн зөвлөгөөнийг гэр бүл залуучуудын газартай хамтран зохион байгууллаа.

2017 оны 05 сарын 16-нд Политехник коллежийн дотуур байрны 30 оюутанд архи, тамхиы хор хөнөөл, эмийн зохистой хэрэглээ сэдэвт сургалтыг зохион байгуулж оюутнуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлсэн.

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн эмч нарын дунд “Сургуулийн эмч нарын тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 11 хүн оролцлоо. Хэлэлцүүлгээс гарсан саналыг хэрэгжүүлэх тухай аймгийн албан даалгавар гаргалаа.

Өсвөр үеийн сурагчдын дунд үе тэнгийн эрүүл мэндийн сургагч бэлтгэж үе тэнгийн сургагчаар дамжуулан, Ирээдүйн босго төвийн үйл ажиллагаа , Бэлгийн болон НҮЭМ, БЗДХ-ын талаарх мэдлэг мэдээллийг түгээх, Хувь хүн болон бүлгийн харилцаа, Үерхэл нөхөрлөл, Сэтгэл гутралаас сэргийлэх эрсдэлт зан үйлээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллээр хангах зорилгоор 2 өдрийн сургалтыг зохион байгуулж нийт 32 үе тэнгийн сургагч бэлтгэлээ.

“Гэр бүл хүүхэд, залуучуудын өмнө үүрэг хүлээгчдын хариуцлага” сэдэвт сургалтанд хамрагдаж гэр бүлийн хүчирхийллийн хууль, хүүхэд хамгааллын хууль, хүүхдийн эрхийн хуулийн мэдээлэлийг 61 хүнд хүргэлээ.

Дөргөн, Зэрэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн өсвөр насны 235 сурагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Эрүүл мэндийн үзлэгээр сурагчдын бие бялдрын хөгжил болон эрүүл мэндийн ахуйн байдлыг үнэлж сурагчдын өндөр, жинг хэмжиж, БЖИ үнэлэхэд сурагчдын 40% хэвийн жинтэй, 27% жин багатай, 2% туранхай, 13,4% илүүдэл жинтэй байлаа. Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан нийт сурагчдын тоо 235 (80.7%) нь эрүүл, зонхилон тохиолдож буй өвчлөлүүд нь шүдний цоорол(15.4%), Гүйлсэн булчирхайн үрэвсэл(11.1%), Фимоз, Парафимоз, Нянгийн гаралтай үтрээний үрэвсэл (7.7%) байсан. “Бэлгийн болон Нөхөн үржихүйн эрүүл” сэдэвт сургалт зохион байгуулж нийт 235 сурагч хамрагдсан. Ховд Их сургуулийн Бага ангийн багшийн 1-4 курсын оюутнуудад “НҮЭМ, БЗДХ, ХДВХ” талаар урьдчилан сэргийлэх тухай сургалтыг зохион байгуулж нийт 78 оюутан хамрагдаж эрүүл мэндийн мэдлэгээ дээшлүүлсэн. Өсвөр үе ирээдүйн босго төвөөр эрүүл мэндийн үзлэгт 243, итгэлтэй утсаар зөвлөгөө авсан 42, сайн дурын шинжилгээнд 15, эмчилгээнд 6 хүн хамрууллаа.

Дархлаажуулалтын хамралтын болон зарцуулалтын мэдээг анхан шатны нэгжүүдээс авч, нэгтгэсэн тайланг 5 сарын 5-ны дотор Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын төвд хүргүүлсэн. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 сарын 02-ны өдрийн А/175 дугаар тушаалын дагуу, Монгол улсын засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Дархлаажуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3, 3.1.6 дахь зорилтод тусгасан “Элэг бүтэн монгол”, “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2017 оны 5 дугаар сарын 10-наас 20-ны өдрүүдэд “Хепатитын В вирусийн халдвараас сэргийлье” уриан дор улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлээ.

Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийн бэлтгэл ажлын хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албанаас 6,095,059.75 төгрөгийн үнэ бүхий Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг вакцин 3200 хүн тун, В вируст хепатитаас сэргийлэх вакцин 2500 хүн тун, аюулгүй хайрцаг 25 ширхэг, найруулдаг тариур 100 ширхэгийг захиалан авч анхан шатны нэгжүүдэд хүргүүлж, тайлан мэдээг авч ажиллаж, дархлаажуулалтын 10 хоногоор “Элэг бүтэн монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хепатитын В вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдаж, халдваргүй байгаа нь тогтоогдсон 40-65 насны 1250 иргэдийг В вирүст хепатитаас сэргийлэх вакцины I дэх тунд хамруулсан. Сарын дараа дээр хамрагдсан хүмүүсийг В вирүст хепатитаас сэргийлэх вакцины II дахь тунд оруулахаар төлөвлөж байна. “Халдварт өвчнөөс

сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 16, 17 настай 2439 сурагчдыг улаанбурхан, улаанууд өвчний эсрэг хавсарсан вакцинаар 96,4 хувьтай хамруулж улаанбурхан, улаанууд өвчнөөс урьдчилан сэргийлж ажилласан 1000 хүн тун туберкулины сорилыг анхан шатны нэгжүүдэд хуваарилан хүргүүлсэн.

Нохойд уруулж ноцуулсан 7 хүнийг галзуу өвчнөөс сэргийлэх вакцинд хамруулж ажилласан. Вакцин, биобэлдмэл хадгалж буй хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн хангалт, засвар үйлчилгээний талаар тайлан бичиж, аймгийн эрүүл мэндийн газрын хөлдөөгчийг шинэчилж өгөх талаар Халдварт өвчин судлалын үндэсний төв рүү санал хүргүүлсэн.

Томуу, томуу төст өвчин болоод халдварт өвчний хам шинж, сэжигтэй өвөрмөц тохиолдлын мэдээг өдөр бүр авч нэгтгэн 7 хоногийн Мягмар гараг бүр Томуугийн үндэсний төв болон Халдварт өвчин судлалын үндэсний төвд EWAR 2.0, Health-info 3.0 програмаар тасралтгүй мэдээлж ажиллалаа. Халдварт өвчин 5 сарын байдлаар гар, хөлний өвчин болон салхинцэцэг илүүтэй бүртгэгдэж байна. Салхинцэцэг, гар хөлний өвчний сэрэмжлүүлэг, зөвлөмжийг анхан шатны нэгжүүдэд e-mail-р хүргүүлсэн. Буянт өрхийн эрүүл мэндийн төв, Цэцэг, Мөст сум дундын эмнэлэгт хяналт үнэлгээ хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Сарын шуурхай мэдээний дагуу 4 дүгээр сарын мэдээг бүх харьяа Эрүүл мэндийн байгууллагуудаас авч нэгтгэн дүгнэлт хийж, эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт тоо баримтаар холбогдох албан тушаалтнуудыг тасралтгүй хангаж 4 дүгээр сарын шуурхай мэдээг 5 дугаар сарын 3-ны дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд цахим болон цаасан хэлбэрээр мэдээлэв.

“Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд Ховд аймгийн Эрүүл мэндийн салбарт ажилладаг эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын мэдээллийг ELEG.HINF.MN программд живж байгаа бөгөөд 5 сарын 22-ны байдлаар 95 хувийн хамрагдалтай байна.

2012, 2013, 2014, 2015, 2016 оны 4 сарын мэдээг 24-н ЭМБ-уудаас авч тулган, эхний 4 сарын байдлаар H-info программд тулгалт хийж, зөрсөн мэдээ баазийг засав.

Эрүүл мэндийн салбарын ажилчдад “ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд (илрүүлэг шинжилгээ болон асуумжийг авах) системийн хэрэглэгчийг шинээр бүртгэв.

Байгууллагын веб сайт шинээр нээх ажлыг эхлүүлээд байна. Байгууллагад засвар орж байгаатай холбогдуулан сүлжээний утасыг шинээр зохион байгуулахаар төлөвлөн бүх сүлжээний хуучин утасыг авлаа. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаатай холбоотой баннерын эх бэлтгэл, сурталчилгааны тараах материалын эх бэлтгэх, “Мянган цагаан нөмрөгтөн” чуулга уулзалтанд байгууллагын товч танилцуулгын самбарын эх, ажил мэргэжлийн уралдаанд оролцсон багуудад дурсгалын фото зураг бэлтгэх, албан хаагчдын компьютерт вирусын программ суулгах ажлыг эхлүүлж одоогийн байдлаар 20 компьютерт тус тус суулгалаа.

Сумдын эрүүл мэндийн төвүүдээр хяналт үнэлгээ хийж, зөвлөн туслах үйлчилгээ явууллаа. Мөн хяналт үнэлгээний үеэр тухайн сум орон нутгийн удирдлагууд болон бусад холбогдох албан тушаалтнуудыг урьж оролцуулан, эрүүл мэндийн чиглэлээр хийгдэж буй ажлууд болон тулгамдаж буй асуудлуудын талаар харилцан ярилцаж, нөлөөллийн ажил хийн, сум орон нутгийн дэмжлэгт удирдлагын дэмжлэгийг авч, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллахаар шийдвэрлэлээ.

Мөн 5 дугаар сарын 20-ны өдөр “Сүүн сэтгэл” холбооны 15 жилийн ойн арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд оролцож, хамтын үйл ажиллагааг уялдуулан, хамтран ажиллалаа.

2017 оны эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон “Эх хүүхдийн ээлтэй тусламж, үйлчилгээ” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор эхний ээлжинд Буянт, Дарви, Ховд, Мөнххайрхан сумдын их эмчийг эх баригчийн хамт 3 хоногийн онол, дадлага хослуулсан сургалтыг Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн Амаржих газартай хамтран зохион байгууллаа.

“Яаралтай тусламжийн цогц менежмент” сургалтыг Түргэн тусламжийн нийгэмлэгтэй хамтран бүх сум өрх, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж нийт 350 гаруй эмч мэргэжилтнүүдийн хамруулан амжилттай зохион байгуулсан. Ингэснээр эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн анхан шатны тусламж үйлчилгээ сайжирч, мэдлэг мэргэжил дээшилсэн.

Багийн эмч нарыг чадваржуулах сургалтанд хамрагдаж байгаа 35 эмчид “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн харилцаа хандлага”-ын талаар мэдээлэл хийлээ.

Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан “1000 цагаан нөмрөгтөн” чуулга уулзалтанд Эрүүл мэндийн газрын дарга, Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, Булган сумын нэгдсэн эмнэлгийн их эмч, багийн бага эмч, Мөнххайрхан сумын эрхлэгч их эмч, Буянт өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, бэлгийн замын халдварт өвчиний их эмч, эх барих эмэгтэйчүүдийн эмч нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй оролцож ирлээ.

Эмнэлгийн тусламжийн чанар яаралтай гамшгийн үеийн бэлэн байдалыг Ховд сумын ЭМТ, Чандмань сумын ЭМТ Булган нэгдсэн эмнэлгүүдэд бүсчилсэн байдлаар бүх сумын эмнэлгүүдийн мэргэжилтнүүдийг хамруулан хэлэлцүүлэн хяналт хийсэн

Эхний улиралд Ховд аймагт 0-1 насны хүүхдийн 11 тохиолдол ба Манхан, Чандмань, Ховд, суманд 4, аймгийн нэгдсэн эмнэлэгт -7 хүүхдийн эндэгдэл гарсныг хэлэлцэж холбогдох эмч эмнэлгийн мэргэжилтэнүүдэд үүрэг даалгавар өгч цаашид сэргийлж болох хүүхдийн өвчлөлдэндэгдлийг гаргахгүй байх арга хэмжээ авч ажилласан.

Тусгай зөвшөөрлийн комиссын хуралыг зохион байгуулан нийт 15 байгуулага сунган ажиллах эрх олголоо. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа 05, 06 сард дуусах Эрүүл мэндийн байгууллагын судалгаа гаргасан. Үүнд: Эмийн эргэлтийн сан 2, хувийн хэвшлийн эмнэлэг 4, хувийн эмийн сан 3, Эм ханган нийлүүлэх бөөний төв 1 нийт 10 байгууллагын материал хүлээн авч бүрдүүлэлтийг хянан, шаардлага хангаагүй баримт бичигт дахин тодруулга хийж тусгай зөвшөөрлийн хурлаар оруулахаар бэлэн болгосон.

Эмийн сангийн үйл ажиллагаа явуулах Чандмань сумын эмийн сангийн байранд, үйл ажиллагаа явуулах байр нь өөрчлөгдсөн эмийн санд тус тус ажлын байрны үнэлгээ хийсэн.

ЭТХ-ийн хүүхдийн тусламж, эхийн тусламж, эмийн чанар аюулгүй байдал, эмнэлгийн тусламжийн чанар хариуцсан мэргэжилтнүүд, хэлтсийн дарга Ховд, Эрдэнэбүрэн, Мөст, Цэцэг суманд ХШҮ хийж зөвлөлөгөө өгч ажиллалаа.

Эх хүүхдийн сувилахуйн тусламж чанарыг сайржуулах сэдэвтэй ажил мэргэжилийн уралдааныг 2 үе шаттай 6 мэргэжлийг хамруулан зохион байгуулсан. Ажил мэргэжлийн уралдааны 1 дүгээр шатыг бүсчлэн Дөргөн, Дуут, Зэрэг, Алтай сумын эрүүл мэндийн төвд багийн эмч, эх баригч, дүн бүртгэгч, бакцинатор, сувилагч 2 оролцуулан зохион байгууллаа. Шалгарсан баг хамт олон аймгийн эрүүл мэндийн газарт болох 2 дахь шатны шалгаруулалтанд оролцож ажил мэргэжлийн шилдгүүдийг тодрууллаа.

Улаанбаатар хотод 2017 оны 05 дугаар сарын 06 сарын 08-наас 05 сарын 10-ны өдрүүдэд “Эх, хүүхдийн сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулъя” сэдэвт сургалт, зөвлөгөөнийг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд зохион байгууллаа. Тус

зөвлөгөөнд Эрүүл мэндийн газрын сувилахуйн тусламж хариуцсан мэргэжилтэн, БОЭТ-ийн сувилахуйн албаны дарга, сувилагчийн төлөөлөл 1, эх баригчийн төлөөлөл 1 нийт 4 мэргэжилтэн хамрагдсан. Сургалтаар “Эх, хүүхдийн сувилахуйн тусламж, үйлчилгээний өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээ”, “Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж”, Жирэмсэн эхчүүдэд зөвлөгөө өгөх арга зүй”, “Нярайн анхны тэврэлт”, “Олон нийтэд түшиглэсэн Хүүхдийн өвчний цогц менежмент”, “Эх, хүүхдийн сувилахуйн тусламж үйлчилгээний алдааны санд бүртгэгдсэн түгээмэл тохиолдож буй, алдаа зөрчил”, Өсвөр насны охидын жирэмслэлт, сувилахуйн тусламж үйлчилгээ”, “Уян зүү тавих арга, техник”, Эх хүүхдийн тусламж үйлчилгээнд хэрэглэх төрөлжсөн сувилахуйн түүх зэрэг сургалтанд хамрагдаж мэдлэг мэргэжлээ дээшлүүлээ.

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа 05, 06 сард дуусах Эрүүл мэндийн байгууллагын судалгаа гаргасан. Үүнд: Эмийн эргэлтийн сан 2, хувийн хэвшлийн эмнэлэг 4, хувийн эмийн сан 3, Эм ханган нийлүүлэх бөөний төв 1 нийт 10 байгууллагын материал хүлээн авч бүрдүүлэлтийг хянан, шаардлага хангаагүй баримт бичигт дахин тодруулга хийж тусгай зөвшөөрлийн хурлаар оруулахаар бэлэн болгож байна.

"2017 оны Бүсийн оношлогоо эмчилгээний төв, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх" тендерийн 2-р улиралын эм, эмнэлгийн хэрэгслэл, лабораторын урвалж оношлуур нийлүүлэгдсэний дагуу 16 сумын ЭМТ-д түгээлт хийлээ.

16 сумын ЭМТ-ийн хүүхдийн эмчилгээ оношлогоонд шаардлагатай болон ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн судалгааг гарган Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлээ.

Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам-ын 4.2.3, 4.5.3 дахь заалтын дагуу сумдын эмийн санг зайлшгүй шаардлагатай эмээр хангах тендер зарлах тухай санал асуулга явуулаа.

2017 оны 05 дугаар сарын 06 сарын 08-наас 05 сарын 10-ны өдрүүдэд “Эх, хүүхдийн сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулъя” сэдэвт сургалт, зөвлөгөөнийг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд Эрүүл мэндийн газрын сувилахуйн тусламж хариуцсан мэргэжилтэн, БОЭТ-ийн сувилахуйн албаны дарга, сувилагчийн төлөөлөл 1, эх баригчийн төлөөлөл 1 нийт 4 мэргэжилтэн хамрагдсан.

Сургалтаар “Эх, хүүхдийн сувилахуйн тусламж, үйлчилгээний өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээ”, “Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж”, Жирэмсэн эхчүүдэд зөвлөгөө өгөх арга зүй”, “Нярайн анхны тэврэлт”, “Олон нийтэд түшиглэсэн Хүүхдийн өвчний цогц менежмент” “Эх, хүүхдийн сувилахуйн тусламж үйлчилгээний алдааны санд бүртгэгдсэн түгээмэл тохиолдож буй, алдаа зөрчил”, Өсвөр насны охидын жирэмслэлт, сувилахуйн тусламж үйлчилгээ”, “Уян зүү тавих арга, техник”, Эх хүүхдийн тусламж үйлчилгээнд хэрэглэх төрөлжсөн сувилахуйн түүх зэрэг сэдвүүдээр сургалтанд хамрагдлаа.

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа 05, 06 сард дуусах Эрүүл мэндийн байгууллагын судалгаа гаргасан. Үүнд: Эмийн эргэлтийн сан 2, хувийн хэвшлийн эмнэлэг 4, хувийн эмийн сан 3, Эм ханган нийлүүлэх бөөний төв 1 нийт 10 байгууллагын материал хүлээн авч бүрдүүлэлтийг хянан, шаардлага хангаагүй баримт бичигт дахин тодруулга хийж тусгай зөвшөөрлийн хурлаар оруулахаар бэлэн болгож байна.

"2017 оны Бүсийн оношлогоо эмчилгээний төв, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд

хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх” тендерийн 2-р улиралын эм, эмнэлгийн хэрэгслэл, лабораторын урвалж оношлуур нийлүүлэгдсэний дагуу 16 сумын ЭМТ-д түгээлт хийлээ.

16 сумын Эрүүл мэндийн төвийн хүүхдийн эмчилгээ оношлогоонд шаардлагатай болон ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн судалгааг гарган Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлээ.

Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам-ын 4.2.3, 4.5.3-дах заалтын дагуу сумдын эмийн санг зайлшгүй шаардлагатай эмээр хангах тендер зарлах тухай санал асуулга явуулаа.

Биеийн тамир, спортын чиглэлээр: 2017 оны 05 дугаар сард Мини волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2 насны ангилалаар зохион байгуулж, нийт 54 багийн 350 гаруй тамирчдыг хамрууллаа. Мөн Нийтийн биеийн тамирын арга хэмжээний хүрээнд Ховд кросс 2017 гүйлтийн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 350 гаруй гүйгчид оролцуулан, Эртэч Ховд аянг зохион байгуулж өглөөний гүйлт, алхалт, хийн дасгалыг хийж байна.

Олон нийтийн арга хэмжээний хүрээнд Эрдэнэбүрэн сумын нутгийн зөвлөлийн тэмцээн, мөн монгол банкнаас зохион байгуулсан банкнуудын аварга шалгаруулах тэмцээнүүд тус тус зохион байгуулагдлаа.

Завхан аймагт болсон баруун бүсийн спортын байгууллагуудын сургалт, зөвлөгөөнд хамрагдан бүсийн биеийн тамир спортын газруудын хооронд зохион байгуулагдсан нөхөрсөг тэмцээнд оролцож 3 байр эзэлсэн амжилтуудыг үзүүллээ.

Уралдаанч хүүхдийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлыг хамгаалах, урьдчилан сэргийлэх нөлөөлийн арга хэмжээг эрчимжүүлэх, уралдаанч хүүхдийн өмнө тулгамдаж буй асуудлыг өөрсдөө нь тодорхойлуулах, шийдвэр гаргах түвшинд хүргэх зорилгоор “Уралдаанч хүүхдийн аюулгүй байдал - Уяач таны хариуцлагаас” чуулганыг Дэлхийн зөн Ховд орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Хүний эрхийн үндэсний комиссын ажилтан, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, аймгийн Алтайн унага МСУХолбоотой хамтран зохион байгууллаа. Чуулганд 17 сумын уяач, уралдаанч хүүхдийн төлөөлөл 164 хүн оролцлоо.

Ховд аймагт үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийд, сүмд шавилан суугч хүүхдийн судалгааг 17 сумаас авч нэгтгэлээ.

Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Ховд аймгийн хамтарсан багийн гишүүдийн хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн ойлголт өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор хамтарсан багийн сургалтыг 2017 оны 05 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулав.

“Хүүхэддээ бахархан дуурайх хүн нь байя” аяныг зохион байгуулах албан бичиг, удирдамжийг сумдад хүргүүлж чиглэл өгч ажилласан.

Хүүхэд хамгааллын бодлого, Хүүхдийн эрхийн тухай хуулиар Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн эцэг эх, багш, ажилтнуудад мэдээлэл хийлээ.

Жаргалант сумын ерөнхий боловсролын 7 сургуулийн сурагчдын дунд 7-8-р ангиудын сурагчдыг хамруулан цахим тоглоомын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сурагчидад сургалт зохион байууллаа.

Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс гэр бүл цуцлалтанд шинжээчээр ажиллах тухай шүүгчийн 2 захирамж ирсэний дагуу Зэрэг сум, Жаргалант суман дахь гэр бүлд ажиллаж, хариуцагч болон нэхэмжлэгчийн гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийж дүгнэлтийг холбогдох газарт хүргүүлээ.

Монгол Улсын нутаг дэвсгэрт гэр бүл хүүхдийн салбарт авч хэрэгжүүлж буй Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, хүүхэд харах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 6540: 2015 стандарт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжид нөхцөл байдлын үнэлгээ хийж шаардлага хангахгүй төвүүдэд албан шаардлага, арга хэмжээний санал өгч, хүүхэд харах үйлчилгээ болон сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн давхардлыг арилгах зорилгоор 2016 оны 05 сарын 07-15-ны хооронд хилийн 8 застав боомт, хүүхэд харах үйлчилгээ эрхэлж буй 10 сум, аймгийн төвийн 11 хүүхэд харах үйлчилгээ эрхэлж буй иргэний байр, төвүүдээр хяналт үнэлгээ хийлээ. Аймгийн хэмжээнд 31 хүүхэд харагчид хөгжлийн бэрхшээлтэй 4 энгийн 147 хүүхэд, аймгийн төвд 52 суманд 99 хүүхэд нийт 151 хүүхэд, хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж байна. Мэрэгжлийн хяналтын газар, Боловсрол соёл урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар зэрэг 3 байгууллагын хамтарсан ааёйí õýñýã õõõàéí ñõí, õèèèéí çàñòàà áííõõí õ¿¿õýä õàõàõ ¿éé=èèäýú ýðõýèæ áóé èðäýäèéí ¿éé àæèèèàãààðàé òàíèèõàæ, ¿íýýýèð ä¿äíýèð õèéсэн. Хяналт үнэлгээ хийх явцад хилийн застав боомтуудын үйл ажиллагаа нь хүүхэд харах үйлчилгээний хууль тогтоомж, журам стандарт шаардлагыг маш сайн хангаж байна. Харин зарим нэг буюу аймгийн төвийн 2 хүүхэд харагч, Үенч сумын 1 хүүхэд харагч, нийт 3 хүүхэд харагчийн үйлчилгээ үйл ажиллагаа шаардлага хангахгүй байгаа тул эдгээр 3 хүүхэд харагчид хугацаатай албан шаардлага хүргүүлжээ. Албан шаардлагын дагуу тодорхой ажлыг хийж гүйцэтгээгүй тохиолдолд үйл ажиллагааг зогсоох арга хэмжээний санал хүргүүлсэн.

Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилгаар Ерөнхийлөгчийн тамгын газар, Монголын үндэсний олон нийтийн телевиз хамтран “Сурагч солилцооны хөтөлбөр”-ийн 17 дахь удаагийн нэвтрүүлэгт Зэрэг сумын 12 жилийн сургуулийн 7-р ангийн сурагч Маргад, Баянхонгор аймгийн Бууцагаан сумын 12 жилийн сургуулийн 7-р ангийн сурагч Алимансар нар оролцож, тухайн орон нутгийн өв соёл зан заншил, ахуй амьдралаас танилцаж суралцсан. Мөн Зэрэг сумын сургуулийн сурагчид болон Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүд Мөрөөдөл хүүхдийн оролцооны байгууллага, Лидер сурагчдын академи зэрэг хүүхдийн оролцооны байгууллагуудын гишүүдтэй уулзаж яриа өрнүүлэн найз нөхөд болсон.

Хүүхэд өсвөр үеийнхэнд Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон Нутгийн төрийн захиргааны байгууллагуудын шийдвэр гаргах үйл ажиллагааны талаар мэдлэг олгох, хүүхдийн эрх ашигтай холбоотой асуудлыг боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх үйл явцад тэдний оролцоог дэмжих зорилгоор аймгийн ИТХ, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн Зөн Ховд орон нутгийн хөгжлийн хөтөлбөр хамтран аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд “Мини Иргэдийн төлөөлөгчдийн хурал”-ыг байгуулах, анхдугаар хуралдааныг 2017 оны 05 сарын 23-ны өдөр зохион байгууллаа. Хуралдаанд 16 сум 23 сургуулийн төлөөлөл, Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүд, Хүүхдийн оролцооны байгууллагын гишүүд зэрэг 41 хүүхдийн төлөөлөл оролцлоо. Аймгийн Мини ИТХ-ын даргад бүлэг тус бүрээс сонгогдсон 12 жилийн 1-р сургуулийн 106 ангийн сурагч Пүрэвжав овогтой Доржзогдоо, Эрдэнэбүрэн сумын 12 жилийн сургуулийн 7а ангийн сурагч Цэрэнбадам овогтой Мөнгөншагай, 3-р сургуулийн сурагч Болдбаатар овогтой Төрсайхан, 12 жилийн 1-р сургуулийн сурагч 10а ангийн сурагч Ганбат овогтой Мөнгөнцоож, Прогресс сургуулийн сурагч Ганбаатар овогтой Загдсүм нар сонгогдсоноос 12 жилийн 1-р сургуулийн сурагч 10-а ангийн сурагч Ганбатын Мөнгөнцоож олонхийн саналыг авч аймгийн Мини ИТХ-ын даргаар сонгогдлоо. Ховд аймгийн хүүхэд багачуудын эрхэмлэх зүйлийн төслийг хэлэлцэн батлаж “Мини ИТХ-ын 04 дүгээр тогтоолоор баталсан. Хуралдаанаас гарсан

санал зөвлөмж шийдвэрийг аймгийн иргэдийн төлөөлөгч, ажлын албанд гардуулан өглөө.

Эрх зүйн орчны шинэчлэлтэй холбоотой гэр бүлд хүүхдийн эрхийг хангахад эцэг эхийн боловсрол, мэдлэг, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор шинэ зууны хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлог, хэрэгцээ, хандлагад тохирсон хүүхдээ сурган хүмүүжүүлэх шинэ арга барил, шийдэлд суралцах, хүний эрхэд суурилсан гэр бүл дэх эерэг харилцааг бэхжүүлэхэд эцэг эхийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх зорилготой “ШИНЭ ЗУУНЫ ЭЦЭГ ЭХЧҮҮД” гэр бүлийн зөвлөгөөнийг Ховд аймгийн Засаг дарга, Хүүхдийн төлөө тэргүүний ивээл дор эцэг эхийн төлөөлөл, сумдын Засаг дарга, нийгмийн бодлогын ажилтнуудад 2017 оны 05 сарын 15 ний өдөр аймгийн ЗДТГ-ын хурлын их танхимд 180 гаруй хүнийг хамруулсан зөвлөгөөнийг ЗДТГ-ын хурлын танхимд зохион байгууллаа.

“Шинэ зууны эцэг эхчүүд” гэр бүлийн зөвлөгөөнөөр ураг удмын тасрашгүй хэлхээ болсон үр хүүхдээ хүмүүжүүлэх үнэт зүйлсийн тухай хэлэлцэн, шинэ зууны монгол хүүхдийн хөгжлийн өнөөгийн байдал, чиг хандлага, орчин үеийн нүүдлийн болон суурьшмал соёл иргэншлийг дагаад эцэг эхийн хүүхдээ сурган хүмүүжүүлэх ур ухаан, мэдлэг, чадвар, харилцаа, хандлага, үүрэг хариуцлагад өөрчлөлт шинэчлэлт хийх шинэ хэрэгцээ шаардлага бий болсон зэрэг асуудлаар хэлэлцэж, дүгнэлт хийж УРИАЛАХ уриалгын төслийг боловсруулж баталлаа.

Үндэсний хэмжээнд өрх толгойлсон эмэгтэйчүүдийн судалгаа гаргаж, байгаа тул 17 сумын ЗДТГ-ын нийгмийн бодлогын ажилтнуудаар дамжуулан уг судалгааг өрх толгойлсон эмэгтэйчүүдийн судалгааг ам бүл, өрхийн орлого, ажил эрхлэлтийн байдлаар нь авч нэгтгэн хүргүүлээ.

Дэлхийн улс орнууд болон Монгол улс жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрийг “Гэр бүлийн өдөр” хэмээн тэмдэглэлт өдөр болгон өнгөрүүлдэг. Энэ өдрийг тохиолдуулан хүүхэд бүрийг гэр бүл, нийгмийн ээлтэй орчинд хүчирхийлээс ангид өсөхөд олон нийтийн ойлголт, хандлага оролцоог нэмэгдүүлэх үүднээс Гэр бүлийн радио FM 104.5, Дэлхийн зөн Монгол Олон Улсын Байгууллагын төлөөлөгчийн газрын “Хүүхдийн хөгжил хамгаалал” хөтөлбөр, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран “БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ ХҮСДЭГ” хүүхдийн гар зураг, шүлэг, зохион бичлэгийн уралдааныг зохион байгуулж тэргүүн байр эзэлсэн 24 хүүхдийг ДЗОУБ-ын шагналаар шагнаж урамшууллаа.

Залуучуудын хөгжлийн асуудлаар үүрэг хүлээгчид болон орон нутгийн залуучуудад залуучуудын хөгжил, утга учиртай оролцооны талаар ойлголт нэгтгэн, орон нутгийн болон үндэсний бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэнд залуучуудын оролцоог хангах, төр болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “Залуучуудын утга учиртай оролцоог хангах нь” семинарыг НҮБ-ын Хүн амын сангийн Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлэгч байгууллагаар сонгогдон ажиллаж байгаа Иргэний боловсролын төвтэй хамтран 2017 оны 5 -р сарын 16-17 -ны өдөр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, хүүхэд залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, Залуучуудын хөгжлийн төвийн зохицуулагч, нийгмийн ажилтан, амьдрах ухааны багш, залуучуудын зөвлөлийн гишүүд, дэмжих бүлэг, сонирхолын бүлгийн гишүүд, болох 35 залуучууд төрийн болон бус байгууллагын асуудлаа тодорхойлж, харилцан туршлагаа хуваалцаж мэдээлэл солилцлоо.

Иргэний Нийгмийн 3 дугаар чуулганд оролцох төлөөлөгчдийг иргэний нийгмийн байгууллага, залуучуудын зөвлөл, хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, төрийн байгууллага, малчин залуучуудын төлөөллөөс 5 хүнийг сонголоо.

Тус чуулган нь залуучуудыг асуудал дагуулсан нийгмийн эмзэг бүлэг биш, харин бүтээлч, хариуцлагатай, эерэг өөрчлөлтийг авчрагч асар их хүч гэдгийг нийгэмд таниулах зорилготой хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, Жаргалант сумын Засаг дарга нарт гардууллаа.

Олон улсын сувилагчийн өдрийг тохиолдуулан "Эх хүүхдийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулая" уриан дор тэмдэглэж, "эрүүл ирээдүйнхээ төлөө хамтдаа" дэвжээ тэмцээнийг БОЭТ Боловсрол соёл урлагийн газраас санаачилан, "эрүүл амьдралын түүчээ" залуучуудын хөгжлийн төв хамтран зохион байгууллаа.

Монгол улсын засгийн газар, НҮБ-ын Хүн амын сангийн хамтран хэрэгжүүлж буй "Залуучуудын хөгжил 2013-2017" төслийн хүрээнд өсвөр үе залуучуудад амьдрах ухааны боловсрол олгох зорилгоор архи, тамхины хор уршиг, хүний бие махбодид ямар нөлөө үзүүлдэг, талаар "Амьдрах ухааны цуврал сургалт"-ыг 2017 оны 5 дугаар сард ШШГА, Өсвөр насны хүүхдүүд, Цагдаагийн алба хаагчдын дунд сургалтыг зохион явууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, Засгийн газрын 190 дүгээр тогтоолоор батлагдсан "Нээлттэй хаалганы өдөр" зохион байгуулах журмын дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харъяа Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Политехник коллеж, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрууд хамтран 2017 оны 05 сарын 11-ний өдөр аймгийнхаа төв талбайд өргөн хэмжээнд зохион байгууллаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас иргэдэд дараах үйлчилгээ үзүүллээ.

Үүнд: Гэр бүлийн харилцаа, хүүхдийн хүмүүжил төлөвшил, хүүхэд, залуучууд, гэр бүлийн салбарт шинээр хэрэгжиж эхлэсэн хууль, дүрэм, журам, хүүхдийн хөдөлмөр, тэвчишгүй хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, гамшиг онцгой байдлын үед хүүхэд хамгаалал, хүүхэд харах үйлчилгээ, хүүхдийн оролцооны байгууллагын талаарх мэдээлэл гарын авлагыг 1500 гаруй иргэдэд хүргэж, мэдээлэл зөвлөгөө өглөө.

Иргэдээс хүүхдийн эрхийн зөрчил, эрсдэлт нөхцөл дэх гэр бүлийн талаарх мэдээлэл хүлээн авч холбон зуучлах үйлчилгээ үзүүллээ. Хүүхэд хөгжүүлэх дугуйлангийн үйл ажиллагааг сурталчилж зуны сургалтанд хамрагдах 100 гаруй хүүхэд шинээр бүртгүүлээ.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харъяа Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Политехник коллеж, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрууд хамтран зохион байгуулсан спортын бага наадмын зорилго нь ажилтан, албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, чиирэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олныг төлөвшүүлэх, мэргэжил нэгт нөхөдтэйгээ танилцах, хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилготой явагдсан спортын бага наадам 2017 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Политехник коллежийн спортын зааланд нэг өдрийн турш амжилттай явагдлаа.

Манай хамт болон бусдыгаа хошуучлан спортын төрлүүдээр дараах амжилтыг үзүүллээ.

Үүнд: сагсны төрлөөр эмэгтэй, эрэгтэй багууд 2-р байр эзэлж мөнгөн медаль, мөн шатрын эрэгтэй төрлөөр н.Төмөрбаатар алтан медаль эмэгтэй төрлөөр О.Олззаяа мөнгөн медиал авч ийнхүү сайхан амжилт гаргаж, багийн нийт дүнгээр 3-р байр эзэллээ.

Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр: 2017 оны 05 дугаар сард ирсэн бичиг 60 ирсэн. Үүнээс хугацаатай бичиг 13, явуулсан бичиг 48, иргэдээс

амаар болон бичгээр нийт 12 өргөдөл хүлээн авч бүртгэл хяналтын карт хөтлөн, биелэлтийг тооцон ажиллалаа.

“Нийгмийн халамжийн тухай” хуулийн хүрээнд тэтгэвэр тэтгэмж, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн талаар зөвлөгөө, мэдээллийг 65 иргэнд, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хууль, болон “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хуулийн хүрээнд үзүүлэх хөнгөлөлт тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх “Ахмадаа ачлая” аймгийн дэд хөтөлбөрийн чиглэлээр мэдээлэл зөвлөгөөг 50 иргэнд, “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох” судалгааны талаархи мэдээлэл, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаар мэдээлэл зөвлөгөөг 35 иргэнд, “Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн мэдээлэл зөвлөгөөг 25 иргэн нийт 200 гаруй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 2017 оны 05 дугаар сарын 10-нд хуралдаж хөгжлийн бэрхшээлтэй 11 хүүхдийг хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын тохирох үйлчилгээнд хамрууллаа. Мөн комиссын гишүүдийн цагийн бүртгэл тайланг нэгтгэж төв комисст хүргүүллээ.

Аймгийн ЗДТГазарт ортопедийн тусгай хэрэгсэл авах хэрэгцээтэй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэрсийг халамжийн сангийн программд шалгаж 47 иргэнд таяг, суултуур, тэргэнцэр, алхуулагч олгож wais программд шивсэн.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний орлогын их үүсвэртэй болгох бүлгийн төсөлд дэмжлэг үзүүлэх зорилгоор Алтай, Булган, Цэцэг, Мөнххайрхан, Дуут, Үенч, Буянт сумдаас 9 бүлгийн төслийг сумын амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцэн батлаж ирүүлсэнийг ХХҮГазрын даргын дэргэдэх зөвлөлөөр дахин хэлэлцэж Алтай сумын “Уран хатгамал” Булган сумын “Үндэсний хувцас” оёдол, Цэцэг сумын “Газар шим” Үенч сумын “Уран ноос” төслийг санхүүжүүлэхээр шийдвэрлэлээ.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийг магадлан итгэмжлэх, нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.9 дахь хэсэгт заасны дагуу олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэх, байгууллагыг магадлан итгэмжлэлд оролцох 6 байгууллагуудын материалыг эх хувь болон хуулбар хувийн хамт хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газар –т хүргүүллээ.

Тайлант сард нийт 40 ажил идэвхитэй хайгч иргэнийг шинээр бүртгэж, 145 иргэний мэдээллийг шинэчлэн, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд идэвхижүүллээ. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMIS программд бүртгэлтэй ажилгүй иргэд 1802 үүнээс эмэгтэй 906 иргэн байна.

Ажил идэвхитэй хайгчдаас 328 иргэнийг ажлын байранд зуучлан оруулж, Шинээр бий болсон 45 ажлын байрыг бүртгэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулан, 486 ажлын байрны захиалга ирж ажил хайгч иргэдээс 436 эмэгтэй иргэн ажилд зуучлагдан орсон байна. Байнгын 200, улирлын 81, түр 155 ирлээ.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд ганцаарчилсан зөвлөгөө 25, бүлгээр 46 иргэнийг хамруулан зөвлөгөө өглөө. Мөн 2017 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдахаар төсөл ирүүлсэн иргэдийн явуулж буй үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, үнэлгээ дүгнэлт өгч ажиллалаа.

2017 оны 5 дугаар сард 2014, 2015 онд олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 77892000 төгрөг орж ирсэн, мөнгөн ХЭДСангийн санхүүжилт 105000000 төгрөг орж ирсэн.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Жаргалант сумаас 138 иргэн жижиг зээл, санхүүгийн дэмжилэгт хамрагдахаар хүсэлтээ ирүүлсэнээс ажлын байранд нь очиж нөхцөл байдлын үнэлгээ хийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 115 иргэнийг голомт банкаар олгох жижиг зээлд хамруулахаар судалгааг хүргүүлэн шийдвэрлэсэн.

Мөн сумдаас 67 төсөл ирсэн сумдад нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах явцдаа нөхцөл байдалтай танилцаж ажилласан.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнес эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар 23 төсөл ирсэн. Эдгээр ирсэн төсөл дээр нөхцөл байдлын үнэлгээ хийн ажиллаж байна.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд 27 төсөл ирүүлсэнээс засаг даргын зөвлөлөөр хэлэлцэж 18 төслийг шалгаруулж гэрээ хийгээд байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, Засгийн газрын 190 дүгээр тогтоолын хүрээнд аймгийн ЗДТГазраас гаргасан хуваарийн дагуу тус газраас 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр аймгийн төв талбайд “Нээлттэй хаалганы өдөр”-ийг өргөн хэмжээнд зохион байгууллаа.

Энэ үйл ажиллагааны хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийн танилцуулга, ажил хайгч ажилгүй иргэдийг бүртгэх, ажлын байрны захиалга ирүүлсэн аж ахуйн нэгж, иргэдийг ажил хайгч иргэдтэй холбож ажилд зуучлах, ажлын байрны захиалга авах, “Нийгмийн халамжийн тухай” хуулийн хүрээнд тэтгэвэр, тэтгэмж, нөхцөлт мөнгөн тэтгэмж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаар зөвөлгөө, мэдээллийг иргэдэд хүргэлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийн талаар сонирхсон 13 иргэнд төсөл, хөтөлбөрт хамрагдахад бүрдүүлэх материалын талаар ганцаарчилсан зөвлөгөө өгч, аж ахуй эрхлэх хүсэлтэй хөтөлбөрт хамрагдах 3 иргэний төслийг хүлээн авлаа.

“Нийгмийн халамжийн тухай” хуулийн хүрээнд тэтгэвэр тэтгэмж, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн талаар зөвлөгөө, мэдээллийг 65 иргэнд, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хууль, болон “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хуулийн хүрээнд үзүүлэх хөнгөлөлт тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх “Ахмадаа ачлая” аймгийн дэд хөтөлбөрийн чиглэлээр мэдээлэл зөвлөгөөг 50 иргэнд, “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох” судалгааны талаархи мэдээлэл, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаар мэдээлэл зөвлөгөөг 35 иргэнд, “Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн мэдээлэл зөвлөгөөг 25 иргэн нийт 200 гаруй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

Мөн дээрх ажлын хүрээнд 05 дугаар сарын 22-25-ны хооронд “Халамжаас-Хөдөлмөр” нээлттэй хаалганы өдөрлөгийг сумдуудад зохион байгуулах хуваарийн дагуу газрын даргаар ахлуулсан баруун бүс хариуцсан ажлын хэсэг, дэд даргаар ахлуулсан зүүн бүс хариуцсан ажлын хэсэг Зэрэг, Дарви, Цэцэг, Мөст, Мөнххайрхан, Мянгад, Дөргөн, Чандмань, Ховд, Эрдэнэбүрэн Манхан сумдад ажиллаа.

Мөн энэ нээлттэй хаалганы өдөрт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Нямдаваа оролцож хөдөлмөр, эрхлэлт нийгмийн халамжийн чиглэлээр төрөөс баримталж байгаа бодлого шийдвэрийн талаар болон хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, иргэдийн асуусан асуултанд хариулж, мөн халамжийн чиглэлээр, болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгч, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд дээрх сумдуудаас залуу малдчыг сонгон шалгаруулж батламж гардуулж ажиллалаа.

Нийт 49 залуу малдыг сонгон авч малчдын хөдөлмөр эрхлэх төсөл хөтөлбөрт хамруулж батламж гардуулж ажиллалаа. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг дэмжих

хөтөлбөрийн хүрээнд нийт сумдуудаас 5 ахмад мэргэжилтнийг сонгон авч батламж гардуулан ажиллалаа.

Мөн бүлгээр хүнсний ногоо тариалахаар төсөл хөтөлбөрт хамрагдсан сумдуудын бүлгүүдтэй гэрээ байгуулан батламж гардуулж ажиллалаа.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Жаргалант сумын Засаг даргын 1/303 тоот албан бичгийн дагуу 2017 оны 05 дугаар сарын 13 –ны өдөр орон нутагт нийтээр зохион байгуулсан мод тарих өдөр Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, харъяа байгууллага Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нөхөн сэргээх төв, “Цагаан уул” ахмадын сувилалын нийт 40 ажилтан, албан хаагчид Бугат үзүүрийн доод хэсэгт байрлах байгууллагын эзэмшлийн 3 га талбайд 110 ширхэг чацарганы мод, 50 ширхэг бургас тарилаа.

Мөн “Цагаан уул” ахмадын сувилалын дэргэд 10 ширхэг чацарганы мод тарьж, сувиллын орчмыг зүлэгний үр цацаж зүлэгжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Жаргалант сумын хөгжлийн бэрхшээлтэй ахмад настан Т.Буянтогтоход нөхцөл байдлын үнэлгээ хийн “Төрөлжсөн асрамжийн газарт асруулагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах” журмын дагуу холбогдох бичиг баримт бүрдүүлэн асрамжийн үйлчилгээнд хамрууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төвийн зохион байгуулагч Л.Уранзаяа, угаагч Б.Энхтуяа нар “Хөгжилтэй хавар” аяныг санаачлан зохион буйгууллаа. Аяны хүрээнд асруулагчдыг агаарт гаргах, асруулагчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн, “Хэн сайн дуулах вэ” сэдэвт караоке тэмцээн зохион байгуулан эхний 2 байранд орсон асруулагчдыг өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төвийн асруулагчдын амрах тав тухтай орчин бүрдүүлэх зорилгоор дотроо хөл нүцгэн явах зориулалттай зам, 2 сандал бүхий сүүдрэвчтэй боллоо. Энэхүү сүүдрэвчийг Койка Олон Улсын Байгууллагын санхүүжилтээр сайн дурын ажилтан И Инь Гён хариуцан хийж гүйцэтгэлээ.

Цагаан уул ахмадын сувилалд 05 дугаар сарын байдлаар Цагаан-Уул ахмадын сувилал нь Мянгад сумын 46 амрагчтай, 443 ор хоног , нийтдээ 3544000 төгрөгийн орлого төвөлрүүлэн ажиллалаа.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын чиглэлээр:

Аймгийн ажил олгогчдод хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах ажлын чиглэл, нийгмийн даатгал, татварын хуулиудын өөрчлөлт, шинэчлэлийг танилцуулах, 2017 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл хүргэх, шилдэг түншлэгч ажил олгогчийг шалгаруулж өргөмжлөх, олон нийтэд сурталчлах, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр зохион байгуулж байгаа “Ажил олгогчдын зөвлөгөөн 2017” зөвлөгөөнийг 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд зохион байгуулав.

Тус зөвлөгөөнийг аймгийн Засаг даргын Тамгын газар, ЭМНД-ийн хэлтэс, Ажил олгогч эздийн холбоо хамтран зохион байгуулав. Энэхүү зөвлөгөөнд Ховд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, салбар байгууллагуудын төлөөлөл зэрэг 150 гаруй хүн оролцлоо.

Ховд аймагт төр, хувийн хэвшилд нийт 700 гаруй ажил олгогч ажилладаг бол тэдний 211 нь төрд, 478 нь хувийн хэвшилд ажиллаж байна. Тэдний төлөөлөл болж өнөөдрийн зөвлөөнд оролцож буй ажил олгогчидод хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах ажлын чиглэл, нийгмийн даатгал, татварын хуулиудын өөрчлөлт, шинэчлэлтийг танилцуулж, 2017 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх, төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл хүргэлээ.

Энэхүү зөвлөгөөний үеэр Шилдэг шимтгэл төлөгч байгууллага, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 3 жил дараалан төлбөр гаргуулаагүй ажил олгогчдод батламж гардуулах үйл ажиллагаа болж Шилдэг шимтгэл төлөгч байгууллагыг шалгаруулан урамшууллаа.

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас сүүлийн гурван жил төлбөр гаргуулаагүй 383 аж ахуй нэгж, албан байгууллагуудад 52,042,668 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүлэхээр болсноос төлөөлөл болгон 3 аж ахуй нэгж, байгууллагуудад БАТЛАМЖ гардууллаа.

Уг зөвлөгөөнийг зохион байгуулсанаар ажил олгогчид нийгмийн даатгалын багц хууль болон эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах нөхцөл боломж бүрдэнэ. Мөн төр, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч илүү үр дүнд хүрнэ гэж үзэж байна. Зөвлөгөөнөөс нийт ажил олгогчдод хандсан зөвлөмж гарган, мөрдөж ажиллахаар боллоо.

Мөн хамтран үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж болон төрийн томоохон байгууллагуудын дунд нийгмийн даатгалын багц хууль болон эрүүл мэндийн даатгалын хуулийн нэмэлт өөрчлөлт болон Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтсийн цаг үеийн мэдээллийн талаарх сургалт зохион байгуулж Одоогоор 17 ажил олгогчийн 451 даатгуулагч хамрагдсан байна.

2017 оны 05 дугаар сарын байдлаар тус хэлтэст 63 албан бичиг хүлээн авч тухай бүрт нь шийдвэрлэн ажилласан бөгөөд 55 албан бичиг тоотыг холбогдох газарт хүргүүлж 5 өргөдөл гомдол хүлээн авч 2 өргөдлийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж, 3 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа явж байна. Даатгуулагч иргэдэд 461 архивын лавлагаа гаргаж хэлтсийн сарын ажлын тайлан, мэдээг холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлж, цаг үеийн асуудлыг хэлэлцэн тодорхой шийдвэрүүд гарган биелэлтүүдийг тухай бүрт нь тооцон ажиллаж байна.

Сайн дурын даатгалд 2017 оны 05 дугаар сард 5200 даатгуулагчийн 485,8 сая төгрөг, 5992 даатгуулагчийн 273,9 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгалын орлого төвлөрүүлсэн байна.

2017 оны 05 дугаар сард өндөр насны тэтгэвэрт 7859 хүнд 7162818.7 мянган төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 1509 хүнд 1233535.8 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 783 хүнд 655073.4 мянган төгрөг, цэргийн тэтгэвэрт 205 хүнд 488303.2 мянган төгрөг, Үйлдвэрийн ослын тэтгэвэрт 36 хүнд 145510,0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг 80 даатгуулагчид 85178975 мян төгрөг, Хөдөлмөрийн чадвараа түр алдагчийн тэтгэмжид 39 даатгуулагчид 3804349 мян төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжид 219 даатгуулагчид 40527023 мян төгрөг, 6 даатгуулагчийн оршуулгын тэтгэмжид 6,000,000 төгрөгийг тус тус олгож зарцуулсан.

Эх хүүхдийн магадлах комиссын ээлжит хурлыг 05 дугаар сард 4 удаа хийж нийтдээ 202 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааны асуудлыг хэлэлцэж 154 иргэний актыг сунгаж, 11 иргэний актыг цуцлаж ажилласны гадна 37 иргэний хугацааны актыг шинээр тогтоосон. Энэ сарын байдлаар мэдээллийн баазад 3106 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэлтэй байна.

Тав: Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын талаар: Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны 05 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавхыг бэхжүүлэх нь" сэдэвт сургалт зохион байгууллаа. Сургалтанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Э.Бат-Идэр болон ахлах

референт Ц.Цэнджав, референт С.Нямбаяр, Ш.Цэцэг-Өлзий, Б.Мөнх-Эрдэнэ, Д.Мөнх-Эрдэнэ, Удирдлагын академийн багш док. М.Амартүвшин, төрийн бус байгууллагын тэргүүн С.Батсүрэн, Л.Булган нар болон 21 аймаг, нийслэлийн Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд 110 хүн оролцов.

Сургалтаар Хяналт-шинжилгээ, үнэлгээний онол арга зүй, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" болон Хэрэглэгчийн үнэлгээний хэрэгцээ ба судалгааны арга зүйн талаарх онол арга зүйн мэдлэг олж авлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу аймгийн "Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, захиргааны болон төсвийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал"-ын төслийг боловсруулж, Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.

Мөн журмын дагуу сум, байгууллагуудын хөтөлбөр, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтнүүдэд хийх "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бэхжүүлэх нь" сургалтын хөтөлбөр боловсруулж, 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөөд байна.

2017 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 91 тогтоолын 118 заалт 69.2 хувь, Ээлжит бус хуралдааны 2 тогтоолын 8 заалт 67.1 хувь, ИТХ-ын 3 тогтоолын 5 заалт 52.0, II хуралдааны 4 тогтоолын 10 заалт 56.0 хувь, нийт 100 тогтоол шийдвэрийн 141 заалт 61.07 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэнийг хяналтаас хасах саналтай тогтоолын жагсаалтын хамт ИТХ-ын ажлын албанд хүргүүлэв.

2017 оны 05 дугаар сарын байдлаар Монгол улсын Засгийн газрын 23 тогтоол, 4 хуралдааны тэмдэглэл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 58 тогтоол хүлээн авч удирдлагуудад танилцуулан, холбогдох хэлтэс, сум, байгууллагуудад олшруулан хүргүүлж, хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

Зургаа: Сумдын мэдээлэл:

Жаргалант сум: Төрийн албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд шинээр түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа багийн нийгмийн ажилтнуудад Үр дүнгийн гэрээний талаарх мэдлэг олгох сургалт зохион байгууллаа.

Иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах, гэр бүлийн орчинд амьдралын зөв хэвшил, зан үйлд сургах, орчны эрсдэлт байдлаас урьдчилан сэргийлж, эрх ашгийг нь хамгаалах, аливаа гэмт хэрэгт өртсөн тохиолдолд хаана, хэнд хандах талаар мэдээ мэдээлэл өгөх зорилгоор Цагдаагийн газрын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөл"-тэй хамтран Дэлхийн зөн Ховд орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 110 иргэнд "Хууль журам-миний амьдралд" сэдэвт сургалт зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор Жаргалант сумын Засаг

даргын 2017 оны 04 дүгээр сарын 26-ний өдрийн А/96 дугаар захирамжаар 31 төрийн байгууллагыг сар бүрийн нэг өдөр “Олон нийтийн эргүүл”-ээр ажиллуулж эхэлсэн ба Захирамжинд заагдсан хуваарьт өдрөө 20.00-00.00 цаг хүртэл цагдаагийн алба хаагчийн хамт тодорхой чиглэлд эргүүл хийн ажиллаж байна.

Цагдаагийн газрын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, хууль эрх зүй, аймгийн эрүү хэв журмын нөхцөл байдлыг таниулах, олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн захиргааны байгууллагыг өргөнөөр татан оролцуулах чиглэлийг баримтлан Цагдаагийн газар, Жаргалант сумын ИТХ-ын дарга нарын хамтран баталсан удирдамжийн дагуу “Мэргэжлээ сольсон нь” арга хэмжээг 2017 оны 05 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд зохион байгуулж дараах 3 асуудлыг шийдвэрлэлээ. Үүнд:

- Жаргалант сумын тодорхой цэгүүд, гэр хорооллын гудамж, талбайг камержуулах,
- Замын тэмдэг тэмдэглэгээ, гарц, уулзварын замыг сайжруулах,
- “Олон нийтийн эргүүл”-ийн хантаазыг Политехник коллежийн хамт олонтой хамтран хийж, эргүүлд багш, оюутнуудыг өргөнөөр татан оролцуулах

Жаргалант сумын ЗДТГ “Архичид аминчлахуй” буюу “АА” нийгэмлэгтэй хамтран “Тунгалаг буянт” бүлгийг байгуулан 7 хоногт 2 удаа архины хамааралтай иргэдийн сайн дурын үндсэн дээр уулзалтыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн <http://jargalant.khovd.gov.mn/> сайтаар дамжуулан сумын мэдээллээ иргэд олон нийтэд түгээж байна. “Сум мэдээллийн сүлжээ” агентлагтай хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд сумын 12 баг, баг тус бүрийн танилцуулга, багийн Засаг дарга, нийгмийн ажилтнуудын танилцуулга тэдгээрийн ажлын онцлог, төлөвлөгөө, Засаг даргын захирамж, тендер, төсөл сонгон шалгаруулалт зэрэг мэдээ мэдээллийг шинэчлэн сайтдаа байршуулан ажиллаж байна. Фээсбүүк хаягаар дамжуулан олон нийтийн үйл ажиллагаа, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан байдлаа цаг тухайд нь нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж байна..

Нийгмийн бодлогын чиглэлээр: Хүүхэд харах үйлчилгээний хуулийн хүрээнд 10 иргэн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдний өдөр дутмын ажилтай танилцах, явцын үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж ажиллав.

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах сарын аяны хүрээнд ажил олгогч эздийн холбоотой хамтран төрийн болон хувийн цэцэрлэгүүдийн тогоочдод “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журам” сэдэвт сургалтыг хамтран зохион байгууллаа.

Хүүхэд хамгааллын хамтарсан багийн хуралдааныг 2 удаа зохион байгуулж үйлчлүүлэгчдэд нөхцөл байдлын үнэлгээ хийж, 2 хүүхдийг цэцэрлэгт хамруулан эхийг нь эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа.

Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр: 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдөр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Дэлхийн Зөн Ховд ОНХХ-тэй хамтран хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдийн дунд 8 цагийн сургалтыг зохион байгуулж явууллаа. Сургалтанд мах, сүүний худалдаа эрхлэгчид цэцэрлэгийн тогооч, нярав зэрэг нийт 61 иргэнийг хамруулж, гарын авлага материалаар хангаж ажиллаа.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/186, сумын Засаг даргын 2017 оны А/95 дугаар захирамжийг хэрэгжүүлэх, ариутгал халдваргүйжүүлэлтийн сарын аяны хүрээнд Бугаан гол, Ургамал, Хан орд, Их буян хүнсний зах, гахай тахианы аж ахуй, өлөн боловсруулах цех, Хишиг эрдэнэ баяжих хиамны цех, захын нийтийн хоолны газар, мал түүхий эдийн Цагаан морь зах, 6 худаг, 35 хашаа, 2300 арьсанд ариутгал халдваргүйжүүлэлтийг нийт 3680 м² талбайд хийв.

Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, ХХААГ-тай хамтран “Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг зохион байгууллаа. Уг зөвлөгөөнд салбар бүрийн төлөөлөл 50 бизнес эрхлэгч хамрагдав.

Сумын 12 багийн 112 иргэн, 6 албан газар, аж ахуйн нэгжүүд 6,5 га талбайд үр тариа, 40,1га талбайд төмс, 65,8га талбайд хүнсний нарийн ногоо, 0,7га талбайд малын тэжээлийн ургамал, нийт 58,6га талбайд жимс жимсгэнэ /шинээр 0,5га/ тариалж, сумын нийт дүнгээр 105,9га талбайд төмс хүнсний ногоо тариалаад байна.

Газар зохион байгуулалт дэд бүтцийн чиглэлээр: Цамбагарав багийн малчдын хорооллын газар эзэмшиж, ашиглаж буй 300 иргэдтэй уулзалт хийж тус уулзалтаар газрын тухай хууль болон газар эзэмшүүлэх гэрээний биелэлтийн талаар танилцуулга хийж, малчдын санал бодлыг сонслоо.

2017 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө болон Ховд хотын 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг сурталчлах ажлын хүрээнд Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай хамтран Нээлттэй хаалганы өдрийг зохион байгууллаа. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 7 байршилд газрын дуудлага худалдааг зохион байгуулав.

Байгаль орчны чиглэлээр: “Бүх нийтээр мод тарих” үндэсний өдрөөр Жаргалант сумын хэмжээний 60 аж ахуйн нэгж байгууллагын 1734 ажилтан албан хаагч нийт 3,4га талбайд 4432 ширхэг мод бут тариалав.

Рашаант багийн нутаг Сарвайдгийн тохой буюу Шаврын тохойд иргэд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглан шавар блок, тоосго цохиж байсныг үйл ажиллагаа бүрэн зогсоов. Сумын ИТХ-ын 2017 оны 82 дугаар тогтоолоор Буянт голын сав дагуу газарт дагаж мөрдөх журмыг шинэчлэн батлуулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран 20 иргэнийг голын сав дагуу газарт ажиллуулж байна.

Ховд хотын төвлөрсөн хогийн цэгээс бусад газар буюу Үерийн далан, Сангийн хэрэм, дулааны II станцаас хойш төгс төв хүртэлх зам дагуух эзэнгүй хур хогийг цэвэрлэх ажлыг зохион байгуулж нийтдээ 12 машин буюу 36м³ хогийг цэвэрлэж хогын цэгт зайлуулав.

Алтай сум: 2017 оны 1 дүгээр сараас эхлэн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид Тамгын газрын даргын баталсан хуваарийн дагуу 14 хоногоор шуурхай жижүүрийн үүрэг гүйцэтгэн тухайн 7 хоногт суманд болсон үйл ажиллагааг нэгтгэн аппаратын хурлаар цахим танилцуулга бэлтгэн хамт олонд тайлагнах ажлыг байнга хийж хэрэгжүүлэн тогтмолжиж байна. Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу мод тарих ажлыг сумын хэмжээнд зохион байгуулж, бургас 400, улиас 60, хайлаас 40 нийт 500 ширхэг мод тарив.

Авто машины улсын үзлэг 2017 оны 05 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд зохион байгуулагдаж нийт 227 тээврийн хэрэгсэл хамрагдлаа.

”Хууль дүрэм миний амьдралд” аяны хүрээнд “Архигүй тамхигүй Алтай хүн” шилжин аялах дарцгийг баг, байгууллагуудаар аялуулж энэ сарын дарцгийг хуваарийн дагуу сумын Соёлын төвд шилжүүлэн өгөв. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баталсан удирдамжийн дагуу сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээний цэг, салбар, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг газруудад хяналт шалгалт хийв. Хяналт шалгалтын явцад ноцтой зөрчил илрээгүй хэдий ч шаардлага хангахгүй жин хэрэглэдэг, авто сэлбэг худалдаалж байгаа дэлгүүрүүдэд хугацаатай үүрэг өгч, зөрчил дутагдлыг арилгуулах талаар сануулга зөвлөмжийг хүргүүлэв.

Сумын Эрүүл мэндийн төвөөс дархлаа тогтоох 10 хоногийн аян өрнүүлэн тус аянд хамрагдвал зохих 389 хүүхдээс 330 хүүхэд хамрагдаад байна. Хувилбар сургалтанд хамрагдсан хүүхдүүд сурсан мэдсэнээ эцэг эхчүүддээ тайлагнав.

Сумын Засаг даргын Тамгын газрын өмнөх талбайд төрийн албан хаагчдын хандиваар цэцгийн мандал хийж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, багийн

Засаг дарга нар, ЗДТГ-ын бүх албан хаагчид хөрс шороо асгаж зүлэг суулган цэцэг тарив.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хоёр жил тутамд нэг удаа зохион байгуулагддаг малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалт 2017 оны 05 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Арга хэмжээний үеэр багуудын дунд соёл, спортын арга хэмжээг амжилттай зохион байгуулж “Алтайн буянт ээжүүд” номын нээлт, сумын авъяастнуудын “Бүсгүй минь чи инээмсэглэж яваарай” урлагийн тоглолтууд тоглогдов.

УИХ-н гишүүн Хууль зүй дотоод хэргийн сайд С.Бямбацогтын санаачлагаар “Оюуны их сорилго” олон төрөлт олимпиадад 5 сурагч амжилттай оролцов.

Дотуур байрны нээлттэй хаалганы өдрийг эцэг эхийн нэг өдөр болгон тусгай төлөвлөгөө гарган зохион байгуулж сургуулийн захирал Х.Түмэндэлгэр, СНА Ө.Алтантуяа, шүдний эмч Мягмардорж, НТТБ-н багш Н.Алтанцэцэг нар эцэг эхчүүдэд мэдээлэл, сургалт хийлээ.

Манхан сум: Бүрэн дунд сургуулийн Эрдмийн баярын үйл ажиллагаанд сумын удирдлагууд оролцож сурлага, урлаг, спортоороо үеийн нөхдөө манлайлан суралцсан хүүхдүүдийг шагнаж урамшууллаа.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Шинэ зууны эцэг эхчүүд” аймгийн гэр бүлийн зөвлөгөөнд Засаг дарга, эцэг эхийн төлөөлөл болон холбогдох мэргэжилтэнг оролцууллаа.

Сумын харьяат аймгийн заан Н.Даваадоржийн алдар тэмдэглэх өдөрлөгийг Баянгол багийн Засаг даргын санаачлагаар хамтран зохион байгуулж нутгийн иргэдэд алдрыг нь түгээв.

Аймгийн ХХҮГ-ын дарга Билэгдэмбэрэлээр ахлуулсан ажлын хэсэг сумын амьжиргааг дэмжих зөвлөлтэй хамтарсан хурлыг зохион байгуулж 5 малчин өрхийг “Малжуулах төсөл”-д хамруулахаар шийдвэрлэлээ.

Сумын ЗДТГ, ИТХ-ын 2017 оны төсвийг программд шивж оруулав. Байгууллагуудын Аудит болон Мэргэжлийн хяналтын газрын актын дутууг гаргаж төлөлтийг тулган баталгаажуулав.

Сургуулийн захиргаатай хамтран дунд ангийн сурагчдаар “Цэвэр орчинд-Эрүүл амьдаръя” сэдэвт нэг өдрийг зохион байгуулж Төгрөг гол багийн Рашаант булгаас бага гүүр хүртэлх хог хаягдлыг цэвэрлэж сурагчдыг Бизнесийн холбооноос дэвтэр балаар шагнаж урамшуулав.

Дунд сургуулийн сурагчид орой үдшийн цагаар сэлгүүцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор багш нар хуваарийн дагуу сумын цагдаатай хамтран оройн эргүүл хийж, гарсан зөрчлийг арилган ажиллаж байна.

Нэгдүгээр ангид элсэн суралцсан сурагчид сурсан мэдсэнээ эцэг эчүүд, багш нартай тайлагнаж “Алтан номын үсгийн таньж уншиж сурсан”-ынхаа баярыг тэмдэглэлээ.

Олон улсын Эко сургууль хөтөлбөрийн анхан шатны буюу “Хүрэл гэрэгэ”-ний болзол хангасан сургуулиудын сургалтанд манай сургуулийн Эко зөвлөлийн ахлагч, Биологийн багш Х.Энх-Отгон, сургалтын менежер Б.Өлзийбаатар нар хамрагдаж, Монгол уран зургийн галерейд болсон “Хүрэл гэрэгэ” гардуулах ёслолд оролцлоо. Мөн энэ үеэр сургуулийнхаа эко чиглэлээр хийсэн ажлын тайлан үзэсгэлэнг гаргаж олон нийтэд сонирхуулахаас гадна бусад оролцогч сургуулиудтай туршлага солилцлоо.

Манхан ахлах сургуулийн “Эко-явган аялал” ахлах ангийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд зохиогдлоо. Аяллын үеэр авхаалж самбаа, хурд, хүч, оюун ухаан сорьсон олон тэмцээн уралдаан зохион явуулж, өв уламжлалаа хайрлан хамгаалах үзлийг сурагчдад олгох ажлуудыг зохион явууллаа.

ХЗДХ-ийн сайд С.Бямбацогтын санаачлагаар зохион явуулсан Англи хэл, Математик, Физик, Сэтгэх чадвар, Нийгмийн ухааны хичээлүүдийн 9,10,11 дүгээр ангийн 5 гишүүнтэй багийн олимпиадад амжилттай оролцож аймгийн 24 сургуулиас 7 дугаар байранд оров.

Олон улсын Эко сургууль хөтөлбөрийн ахисан түвшний сургалтанд хамрагдсан багш Х.Энх-Отгон, Б.Өлзийбаатар нар сургуулийн гадаад, дотоод орчны үнэлгээ хийх талаар сургалт явуулж заавар өгч санал бодлоо солилцов. Төгсөх ангийн сурагчдын эрдмийн баярын үйл ажиллагааг багш, эцэг эхтэй нь хамтран зохион явууллаа.

Сургуулийнхаа гадаад орчныг сайжруулах зорилгоор нийт багш, ажилчид хамтран мод, бут тариалан ажиллаж байна. Шинээр 200 гаруй мод, бут тарьж, усалгааг нэмэгдүүлэх зорилгоор шинээр худаг гарган усалгаа хийж ногоон бүс, цэцэрлэгжүүлэлтийг сайжруулан ажиллаж байна.

Хичээлийн жил дуусч байгаатай холбогдуулан анги дэвших болон төгсөх шалгалтанд орох сурагчдын давтлагыг эрчимжүүлж, багш нар уртасгасан цагаар ажиллаж байна. Анги дэвших болон төгсөх шалгалтууд явагдаж байна.

Соёлын төвийн өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, тайз гэрэлтүүлгийн асуудлыг шийдвэрлэх хөрөнгө босгох зорилгоор “Аз дагуулсан аялгуу” урамшуулалт концерт бэлтгэн тоглов.

Сурагчдын мөнгөн хонхны баярыг тохиолдуулан ахлах ангийн сурагчдын дунд “Хаврын баяр-Бүжгийн баяр” цэнгээнт бүжгийн тэмцээн зохион байгуулж 11б тэргүүн байр, 12а анги дэд байр тус тус эзлэв.

Хүнд өвчний улмаас гадаадад эмчилгээнд явах болсон Ч.Гантуяад дэмжлэг үзүүлэх “Олны хүч-Оломгүй далай-13” тоглолтыг зохион байгуулав.

Тахилт багийн нутаг Хороон үзүүрт ухагдсан Хиргисүүр дээр цагдаа, байгаль хамгаалагч нартай очиж нөхцөл байдалтай танилцаж холбогдох газарт нь асуудлыг танилцуулав.

Цэцэрлэгийн бага бүлгийн нийт эцэг эхийн дунд амны хөндийн эрүүл ахуй, гарын ариун цэвэр, бэлтгэл бүлгийн эцэг эхийн дунд “Сургуульд хүүхдийг бэлтгэх нь” сэдвээр, ахлах бүлгийн эцэг эхийн дунд “Шагайн наадам буюу шагайгаар наадацгаая” сургалтыг тус тус зохион байгууллаа.

4 настай хүүхдүүдийн дунд “Захчин дуу”-ны уралдаан, 2 настай хүүхдүүдийн дунд “Шагайгаар наадацгаая, дүрсийг таньцгаая” сэдэвт тэмцээн явуулж эцэг эхийг татан оролцууллаа.

Цэцэрлэгийн “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 05 дугаар сарын 18-ны өдөр тусгай удирдамжийн дагуу явуулж эцэг эх, иргэдийг оролцуулж “5-6 настай хүүхдийн хөгжил” сэдвээр сургалт, Хүүхэд, эцэг эхийн бүтээсэн номоор үзэсгэлэн, Хоолны амталгаат үзэсгэлэн, сэтгэл ханамжийн судалгаа авлаа.

Бага бүлгийн хүүхдээс заасан дуу, шүлэг, ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох асуулгаар, дунд, ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдээс ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох асуулгаар мэдлэг оюуны түвшинг тогтоож ахицыг үнэллээ.

Бага, дунд, ахлах бүлгүүдийн нийт хүүхдийн сурсан мэдснийг тусгай удирдамжийн дагуу бүлэг бүрийн хэмжээнд зохион байгуулж эцэг эхэд тайлагналаа.

Аймгийн БСГ-аас ирүүлсэн Бэлтгэл бүлгийн хүүхдийн мэдлэгийн түвшин тогтоох судалгааг хугацаанд нь бүлгийн багш, ЗАН-ийн ахлагчийн оролцоотой гаргаж хүргүүлэв.

Баг, байгууллагуудын удирдах ажилтнуудын дунд “Хувилбарт сургалт” сэдвээр сургалт, мэдээлэл өгч хамтран ажиллахыг санал болгож ажиллалаа.

Эрүүл мэндийн төв нь 4 их эмч, 22 ажилтан, нийт 26 орон тоотойгоор иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байна. 05 дугаар сарын 26-ны

байдлаар 972 хүнд үзлэг шинжилгээ хийсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 428 хүн хамруулсан ба эмнэлэгт 52 өвчтөн хэвтэн эмчлүүлж байна.

Товлолын дархлаажуулалтанд 2 сартайгаас 2 нас хүртэлх 61 хүүхэд хамруулсан ба 3 эх эсэн мэнд амаржуулж, түргэн тусламжийн 9 дуудлагад үйлчилсэн байна.

0-5 насны хүүхдийг сар бүр жигнэж, хүүхдийн өсөлт бойжилтонд байнгын хяналт тавин ажиллаж байна. Хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдэд стандартын дагуу 210 нэр төрлийн эмээр үйлчлэв. Сумын Засаг даргын Захирамжаар орон нутгийн татвар бүрдүүлэлтийн ажлын хэсэгт орж ажиллалаа.

Ерөнхийлөгчийн Зарлигаар жил бүрийн 05, 10 дугаар сарын 2 дахь долоо хоногийн Бямба гарагийн мод тарих өдрийг тохиолдуулан сумын хэмжээнд “Мод тарих” хөдөлгөөнийг өрнүүлж баг, байгууллага, аж ахуй нэгжүүдэд албан тоот хүргүүлэн ажиллалаа. Үүнд: Бүрэн дунд сургууль хайлаас 200ш, шар хуас 40ш, улиас 100ш, бургас 40ш нийт 380ш мод, Хүн эмнэлэг үхрийн нүд 50ш, улиас 20ш нийт 70ш мод, Соёлын төв шар хуас 30ш, хайлаас 30 нийт 60ш мод, Улаанхүрээ багт иргэн Ж.Галсан чацарганы мод 500ш, хайлаас 300ш, сумын хэмжээнд нийт дүнгээр 1310 ширхэг мод тарьж 1 620 000 төгрөгийн зардал гаргаж ногоон байгууламж нэмэгдүүлэн ажиллалаа.

“Цэвэр орчинд-Эрүүл амьдаръя” уриалгыг сумын хэмжээнд өрнүүлж албан байгууллага, айл өрхүүдтэй хамтран орчны хог хаягдлыг цэвэрлэх цэвэрлэгээг зохион байгууллаа. Цэвэрлэгээнд сурагчид болоод иргэд нийлсэн 560 гаруй хүн хамрагдаж 9 тонн хог хаягдлыг бөгнүүлж хогийн цэгт хүргүүлэв.

Аймгийн Хүнс, ХАА-н газарт мал төллөлтийн мэдээг долоо хоног бүрийн 3 дахь өдөр тогтмол өгч байна. МЭҮН-үүд Шөвөг яр, ДХХ, Галзуу, Цусан халдварт, Сахуугийн вакциныг хийв. Стандарт хэлжилзүйн газартай хамтран дэлгүүрүүдэд үзлэг шалгалтыг хийж тохиролын гэрчилгээ олгов. Мөн сумын газар тариалангийн бүс газруудаар явж хяналт шалгалт хийсэн. Газар тариалангийн мэдээг 7 хоног бүрийн даваа, пүрэв гарагт гаргаж ХХАА-н газарт мэдээлж байна.

Мянгад сум: Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл:

Тус сумын Засаг даргын Тамгын газар нь Бүх нийтээр мод тарих тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилтийг хангах зорилгоор айл өрх, албан байгууллага, хамт олон бүх нийтээр мод, бут, сөөг, цэцэг тарьж, арчлан хамгаалж, түүнийгээ амьдралын хэв маяг болгон хэвшүүлэн сурталчилж ажиллахыг уриалсантай холбогдуулан Төрийн албан хаагчид болон ард иргэдэд цэцэрлэгт хүрээлэнд мод тарих үйл ажиллагааг зохион байгуулав.

Мөн 05 дугаар сарын 23,24,25-ны өдрүүдэд Засаг даргын Тамгын газрын санаачилгаар Ахмад-идэр-залуу гурван үеийн “Алтан хэлхээ” малчдын чуулга уулзалтыг амжилттай зохион байгуулав. Малчдын чуулга уулзалтанд аймгийн ЭМНДТ, ХХААГ, Швейцарын хөгжлийн агентлаг, ногоон алт хөтөлбөрийн Ховд аймаг дахь бэлчээр ашиглагчдын холбоо ТББ-ын гүйцэтгэх захирал, Улсын их хурлын гишүүн О.Батнасан нар оролцов.

Иргэний бүртгэл мэдээллийн чиглэлээр: Иргэний бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны хүрээнд шинээр төрсөн хүүхэд 8, гэрлэлт 2, нас баралт 3, үрчлэлт 1, шилжин явсан 8, шилжин ирсэн 7, хашаа байшингийн гэрчилгээ шинээр авах 2, иргэний хүсэлтийг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэсэн болно.

Хөдөө аж ахуй, байгаль орчин, газрын харилцааны чиглэлээр: Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Бүх нийтээр мод тарих өдрийг угтан хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан иргэд, аж ахуй нэгж, албан байгууллагад хүргүүлэн ажилласнаар сумын хэмжээнд нийт 350 ширхэг мод тарьж ногоон байгууламжийн бар хүрээг нэмэгдүүлэв. Сумын Засаг даргын Тамгын газар 200, Ерөнхий боловсролын сургууль 50, Хүүхдийн

цэцэрлэг 50, Эрүүл мэндийн төв 50 ширхэг тус тус мод бут тариалав. Тус арга хэмжээнд 500.0 мянган төгрөгийн төсөв зарцуулсан байна.

Ард иргэдийн цэвэр орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчноо цэвэр байлгах, амьдралын зөв хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор Баянхошуу багийн нутаг дэвсгэрт нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгууллаа. Цэвэр цэмцгэр Мянгад сум дэд хөтөлбөрийн хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, талбайд хогийн сав бий болгох зорилгоор судалгааны ажлыг явуулж, хямд өртөгөөр бат бөх чанартай хогийн сав 10 ширхэгийг суурилуулахаар төсвийн төсөл боловсруулж 1522.0 мянган төгрөгийн санхүүжилтийг сумын ИТХ-ын тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, хогийн сав хийх, байршуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн 7 иргэний өргөдөл хүлээн авч 6 өргөдлийг Засаг даргын захирамжаар бүрэн шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа байна. Мөн энэ сард хамтран өмчлөлөө салгуулсан 66 иргэний судалгаа, нөхөн сэргээх газар, Зүй ёсны эрхийг бүртгэн баталгаажуулах судалгаануудыг тус тус гаргаж аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт хүргүүлээ.

Газрын төлбөр төлөгч иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудын төлбөрийн ногдуулалтыг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар болон аймгийн Татварын албанд хүргүүлсэн, энэ онд газрын төлбөрт 3500,0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 2017 оны 01 дүгээр улирлын байдлаар 2200,8 мянган төгрөгийн орлогыг аймгийн Төрийн сангийн дансанд төвлөрүүлээд байна.

Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажил цаг хугацаандаа хийгдэж 23000 ишгэнд шөвөг яр, 1400 үхэрт боом, 200 үхэрт дуут хавдар, 3000 малд цусан халдвар, 20000 малд сохор догол, 8000 малд ДХХ-ээс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт хийгдлээ. Сумын хэмжээнд 10300 малд паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх туулгалт боловсруулалт хийж 111 хашааны 85100м² талбай, 14 уст цэгт ариутгал халдваргүйжүүлэлт хийлээ.

Сумын хэмжээнд 60 га-д тариалалт хийгээд байна. Үүнээс 42га-д төмс, 3.0га-д манжин, 3.0га-д лууван, 1.0га-д байцаа, 2.0га-д сонгино, 8.0га-д тарвас, 3.0га-д амтат гуа тариалав. МЭҮН-дэд 3800,000 мянган төгрөгийн санхүүжилт олгож малчдад үйлчлэх боломжоор ханган ажиллаж байна

Нийгмийн бодлогын салбарын үйл ажиллагааны мэдээлэл:

Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд тэжээгчээ алдсаны тэтгэмжид нийт 19 иргэнд 1216,0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэрт 104 иргэнд 14560,0 мянган төгрөг болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжид нийт 23 иргэнд 1472,0 мянган төгрөг, Жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжид 54 иргэйд 2160,0 мянган төгрөгийн тэтгэмж тус тус олгов.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 18412.0 мянган төгрөг, Иргэний Сайн дурын даатгалд 51 иргэнээс 2250.3 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалд 28 иргэнээс 1387.0 мянган төгрөгийг тус тус орууллаа. Мөн 5 иргэнээс тэтгэвэр тогтоолгох өргөдөл хүлээн авч хувийн хэрэг бүрдүүлэн тэтгэвр тогтоолтыг хийлээ.

Нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэврийн даатгалын санд 98125.0 мянган төгрөгийн санхүүжилт авч өндөр насны тэтгэврийг 289 хүнд 71063.0 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 32 хүнд 6776.0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийг 74 хүнд 15748.0 мянган төгрөг, ҮОМШӨ-ний сангаас 1 хүнд 305.3 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг тус тус олгов.

Эрүүл мэндийн төв нь энэ сард нийт 263 амбулаторийн үзлэг хийж 37 иргэнийг хэвтүүлэн эмчилж, 22 алсын дуудлагад явж, 0-3 сартай 3 жирэмсэн эхийг эрт хяналтанд авч, хөх умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих нийт 13 эмэгтэйчүүдийг 100 хувь шинжилгээнд хамруулж ажиллалаа. “Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд

сумын нийт 40-65 насны иргэдийн судалгааг гаргаж элэгний В,С вирус илрүүлэх үзлэг шинжилгээг хийж эхлээд байна. Сумын хэмжээнд 40-65 насны 625 хүнийг элэгний В,С вирусын шинжилгээнд хамруулахаар графикт төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Эрүүл мэндийн төвийн эмч ажилчдад туберкулины сорил тавьж, 21 хүнд В гепатитийн вакцин хийв. Эрүүл мэндийн салбар зөвлөлөөс ард иргэдийн дунд хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх зорилгоор нийтийн дасгал хөдөлгөөн хийж хэвших аян өрнүүлж нийт 48 хүн өдөр бүр идэвхтэй дасгал хийж тогтмолжиж байна.

Сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр: “Өсөх нахиа Хүүхдийн цэцэрлэг нь 2017 оны 5 дугаар сард төлөвлөсөн төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай, 2 дугаар улиралд хийсэн ажлын тайлангаа танилцуусан ба Б.Болорсүвд багштай бэлтгэл бүлгийн хүүхдүүд эцэг эх, ах эгч нартаа өөрсдийн бэлдсэн дуу хуураа өргөн барилаа. Мод тарих өдрийг зохион байгуулан багш ажилчид, эцэг эхийн оролцоотойгоор 50 ш улиас тариалсан болно. Цэцэрлэг минь баяртай нээлттэй хаалганы өдрийг 5 дугаар сарын 29-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Үенч сум: Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэн “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр Хилийн цэргийн анги 1000 ширхэг чацаргана, 200 ширхэг бургас улаан хашааны ар талд засмал зам дагуу, ЗДТГазар 1000 чацаргана, ЭМТөв 200 чацаргана, Сургууль 500 чацаргана, Цэцэрлэг 300 чацаргана, иргэд 1100 чацаргана, бургас 200, бусад төрлийн жимсний мод 190 нийт 4690 мод сумын хэмжээнд мод тарих ажлыг зохион байгуулав. Баг, албан байгууллагад тус бүр 3га газар тариа, ногоо тарих зориулалтаар эзэмшүүлэв. Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг угтаж ажлын төлөвлөгөө гаргаж суваг шуудуй цэвэрлэж сэргээх, мод усалгааны эх гаргах ажлыг зохион байгуулав.

Аймгийн мэргэжлийн хяналтын газрын зөвлөн туслах баг сургууль, дотуур байрны үйл ажиллагаа, үдийн цай, барилга байгууламжтай танилцаж үнэлгээ дүгнэлт гарган ажиллалаа. ХЗДХ-ийн сайд, УИХ-ын гишүүн С.Бямбацогт, УИХ-ын гишүүн О. Батнасан нарын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан “Оюуны их сорилго” олон төрөлт олимпиадад гадаад хэлний багш Д.Анх-эрдэнэ, 9-а ангийн сурагч А. Анужин, 10-б ангийн сурагч Э.Билгүүндалай, 11-а ангийн сурагч С.Буянхишиг, 11-а ангийн сурагч Д.Энхтүвшин, 11-а ангийн сурагч Б.Бямбасүрэн нарын 5 сурагчид амжилттай оролцов.

Ховд-2017 “Мини волейбол”-ын ААШТ-ээс 13-14 насны ангилалд А.Өмирузах ахлагчтай эрэгтэй баг тамирчид 1-р байр алтан медаль, А.Энххишиг ахлагчтай эмэгтэй баг тамирчид 3-р байр хүрэл медаль, 12 хүртэлх насны ангилалд Э.Сэргэлэн ахлагчтай эрэгтэй баг тамирчид 1-р байр, алтан медаль, эмэгтэй баг тамирчид шигшээ 8-д шалгарч, 8-в ангийн сурагч А. Өмирузах Ховд аймгийн “Шилдэг тамирчин”-аар, багаараа улсын аваргад оролцох эрхээр шагнагдлаа. Багш Б. Цогоо, Д. Долгормаа, М. Цэвэлмаа нарын удирдсан төгсөх 12 дугаар ангийн 3 бүлгийн 70 гаруй сурагчид голын хойд талын талбайд шинээр 160 ширхэг чацарганы суулгац тарьж ногоон төгөл байгуулав. Б. Эрдэнэчимэг, Т.Отгон, Д. Нямцэцэг багштай 1-а,б,в ангийнхан “Уншиж, бичиж, бодож сурсан”-ны баяраа 5-р сарын 5-нд сумын соёлын төвд тусгай хөтөлбөр удирдамжийн дагуу тэмдэглэн өнгөрүүллээ. М.Даваажав, Б.Ууганцэцэг, Т.Баяржаргал нарын удирдсан 5-а,б,в анги, Д.Соёл-Эрдэнэ, Л.Даваажаргал багштай 9-а, б анги, Б.Цогоо, Д. Долгормаа, М.Цэвэлмаа багштай 12-а, б, в ангиудын төгсөх ангийн “Эрдмийн баяр”-ыг тусгай хөтөлбөрийн дагуу 2017 оны 5-р сарын 12-нд тэмдэглэн өнгөрүүлж БСУГ-ын “Эрхэм үйлстэн” тэмдгээр 9-а ангийн багш Д.Соёл-Эрдэнэ, 5-а ангийн багш Б.Ууганцэцэг нар шагнагдав. “Шилдэг төгсөгч”-өөр 2 сурагч, спортын зэрэгтэй 12 сурагч, нийт 50 гаруй сурагчдыг шагнаж урамшууллаа.

Улсын “Кенгару” математикийн олимпиадад К.Орталык багштай 4-а ангийн сурагч Б.Чинболор 3-р байр хүрэл медаль, Ж.Даваасүрэн багштай 2-в ангийн сурагч Энхмэнд 2 дугаар зэргийн диплом, М.Даваажав багштай 5-б ангийн сурагч Х.Тэмүүжин 2-р зэргийн диплом, 7-в ангийн сурагч Билэгмаа 3-р зэргийн диплом, Э.Болормаа багштай, Ц.Цэнгэлмаа багшийн бэлтгэсэн 8-а ангийн сурагч С.Анужин 3-р зэргийн диплом хүртсэн амжилт гаргасан байна. Сургуулийн захиргаа, байрны багш нар хамтран дотуур байрны сурагчдын эцэг эхэд урилга хүргүүлэн 2017 оны 5-р сарын 17-нд “Дотуур байрны эцэг эхийн нэг өдөр”-ийг тусгай хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулан явууллаа.Энэ үйл ажиллагаанд нийт 37 эцэг эх оролцов.

Сургуулийн захирал, сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, байрны багш, жижүүр нар мэдээлэл, хэлэлцүүлэг хийж дотуур байранд тулгамдаж буй асуудлын талаар эцэг эхтэй харилцан ярилцав. Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ 2 дахь гэр болох тасаг байрыг өөрсдийнхөө хүч бололцоог ашиглан бидэнтэй хамтарч засварлаж, тохижуулахаар боллоо.

2016-2017 оны хичээлийн жил дуусаж байгаа тул захирлын тушаалаар улсын шалгалтын комисс байгуулагдан, шалгалтын хуваарийн дагуу 2017 оны 5 дугаар сарын 18-аас анги дэвших болон төгсөх улсын шалгалтыг зохих журмын дагуу авч эхлээд байна.

Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн баг хамт олог хачигт халдвараас сэргийлэх талаар ард иргэдэд сургалт сурталчилгааг хийж дараах ажлуудыг зохион байгуулав. Цагаан түнгэ, Жаргалан, Нарийн гол Хөх-Үзүүр, нийт 90 гаруй малчин иргэдийг сургалтанд хамруулж “Хачигт халдвар өвчин”-ий талаар тэдэнд мэдээлэл, зөвлөмж өгч, тус мэдээллийг албан байгууллагуудын мэдээллийн самбарт байршуулж иргэдэд сэрэмжлүүлэг өгөв.

Хөх үзүүр, Жаргалан, Цагаан түнгэ, Улиаст багуудын иргэдэд В, С вирусийн илрүүлэг үзлэг, шинжилгээг хийж В гепатитын вакцинд 79 иргэнийг хамруулсан болно.

Цэцэг сум: Њóíúí ÈÕÕ 3 óääà хуралдаж давхардсан òííííð 12 àæèè àñóóääëüä öýëýëöýí øèèääýðëýæ 10 òíäòíë äàðääæ 8 õ¿íèèä ò°ðèéí íáíí íääääëüä øääíóóèàòààð òíèáíääíò äàçàðò òèàìæèäv.

Ýíèéí ýðäýèðèéí ñáí, ¸í÷ òàíääàèèò ç°äè°è, Õýðýäëýä÷äèéí ýðò àøäèèä òàíääàèèò ç°äè°èèèä òòñ òòñ øèý÷÷ëýí äàðäèèèä.

Засаг даргын Тамгын газрын ажлын мэдээ: Цэцэрлэгт хүрээлэнгийн худагны засварын ажлыг хийж дуусган нэмж 2 худаг шинээр гаргаж хүлээн авав.

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Уранчимэгээр ахлуулсан ажлын хэсэг хөшөөт багийн иргэдтэй уулзалт хийж, багийн иргэдийн санал бодлыг сонсож ажилдаа тусган ажил хэрэг болгохоор төлөвлөн ажиллаж байна.

МоЭнКо ХХК дүүцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 2000 мод суманд тарьж услалтын систем хийв. Ингэснээр сумын ногоон байгууламж нэмэгдэж нэг иргэн ажлын байртай болсон. Улсын авто үзлэгийн оношлогоонд сумын тээврийн хэрэгсэл эзэмшигчид идэвхтэй оролцож, зөрчилтэй техник хэрэгсэлий зөрчлийг арилган хасалт хийж, хий нэмэгдэх татвараас чөлөөлөв.

ЭМТ-ийн 80 жилийн ойн арга хэмжээг угтан нутгийн брэнд бүтээгдэхүүн шалгаруулах төслийг иргэдийн дунд нээлттэй зарлаж, холбогдох баримт бичгийг хүлээн авч иргэдэд түргэн шуурхай үйлчилгээг үзүүлэв.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн хязгаарыг ИТХ-ын тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлууллаа. Тус сангаас зээл аваад хугацаа хэтэрсэн иргэдтэй ажлын хэсэг уулзаж эргэн төлж барагдуулах хугацаатай сануулга өгч ажиллав.

Аймгийн мэрэгжлийн хяналтын газраас худаг усны, ашиглалт хамгаалалтанд хяналт тавьж усыг хэрхэн ашиглах, хамгаалах зөвлөмжийг холбогдох албан тушаалтан иргэдэд өглөө.

“Хүүхэд гэр бүлдээ жаргалтай”, “Хүүхэддээ бахархан дууриах аав ээж нь байя” аяныг сум, байгууллагынхаа хүрээнд төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн, үр дүнг тооцон ажиллаж байна. Хамтарсан багаараа сар бүрийн тогтсон өдрүүдэд “Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэе” сургалт, “Хүүхдийн хүмүүжил гэр бүл” сэдэвт 3 үеийн уулзалтыг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нийт 310 иргэд оролцож санал бодлоо солилцон, зөвлөмж гарган хэрэгжилтийг хангаж ажиллахаар төлөвлөөд байна. Аяны хүрээнд Гар зураг, Зохион бичлэг, Захидалын уралдааныг зохион явуулж оролцсон сурагчдыг урамшуулан, эцэг эх, сурган хүмүүжүүлэгчдэд хүүхдийн дуу хоолойг хүргэж ажиллаа.

Цэцэг сумын Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/40 дугаар захирамж БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын даргын 2017 оны 05-р сарын 11-ны өдрийн 10/2786 тоот албан бичгийн дагуу Хамгаалалтын захиргааны дарга Д.Пүрэвдорж, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Т.Уранбаяр, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн Д.Эрдэнэтуяа, байгаль хамгаалагч Ч.Галбадрах, Ц.Ганзориг, БОХ-ын улсын байцаагч Ц.Баасанхүү орлогч дарга Б.Одонбаяраар ахлуулсан ажлын хэсэг Цэцэг сумын баян овоо багийн нутаг “Цагаан эрэгт”-т хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийж буй “Өгөөжтэй өв” ХХК-ны үйл ажиллагаатай танилцаж ажлын гүйцэтгэл явцтай танилцаж, хөндөгдсөн газрын техникийн нөхөн сэргээлтийн ажил 70,2% дүгнэлт гаргасан болно.

“TNC” төслийн ахлагч Д.Цэвээнравдан, аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн н.Цэен-ойдов, төслийн мэргэжилтэн н.Ганхуяг нар төслийн талаарх танилцуулга мэдээлэл хийв. албан байгууллага, ААН, нөхөрлөлийн төлөөлөл нийт 40 гаруй иргэд оролцлоо.

“Олон нийтийн оролцоот сургууль” төслийн багийн гишүүд эцэг эхийн төлөөллийн хамт Жаргалант сумын ЕБ-ын II сургуулийн арга хэмжээтэй танилцаж, туршлага солилцон сайн туршлагыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Аймгийн Эрүүл мэндийн газрын хяналт үнэлгээний баг сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай танилцан онол, ур чавдар мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажиллаа.

Чандмань сум: Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны мэдээлэл:

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 1 удаа хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд: Сумын бүрэн дунд сургуулийн Физикийн лабораторийг тус сургуулийн ууган төгсөгчийн нэг ахмад физикч доктор профессор Содномдаржаагийн Мягмарсүрэнгийн нэрэмжит болгох, Сумын эрүүл мэндийн төв үүсэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, эмнэлэгийн төрөх тасгийг тус эмнэлэгийг үүсгэн байгуулагчийн нэг ахмад сувилагч Дорлигийн Лхаасүрэнгийн нэрэмжит болгох, тус эмнэлэгийг тасралтгүй 37 жил удирдаж ажилласан Монгол улсын “Хүний гавьяат эмч” Түвдэнгийн Данзанлхагвын нэрэмжит болгох асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Мөн “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” зөвлөлөөс суманд үйл ажиллагаа явуулж буй дэлгүүр, ТҮЦ, гуанз, цайны газар, төсөвт байгууллагуудын хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, хадаглалт хамгаалалтад хяналт шалгалтыг өндөр түвшинд хийж, илэрсэн зөрчлийг хэрхэн арилгах заавар зөвлөмжийг албан бичгээр аж ахуйн нэгж, албан байгууллагуудад хүргүүлэв.

Сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл: Тамгын газар нь аппаратын өргөтгөсөн хурлаар нээлттэй хаалганы өдөрлөг, уул усны тахилгын баярыг хэрхэн хамтарч зохион байгуулах талаар санал бодлоо солилцов.

Сумын хяналт үнэлгээний жилийн ажлын төлөвлөгөөний дагуу Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг дэлгүүр, ТҮЦ, гуанз, цайны газар, төсөвт байгууллагуудын хүнсний эрүүл аюулгүй байдал, хадаглалт хамгаалалтанд хяналт шалгалтыг хийж зөрчилтэй аж ахуйн нэгж, албан байгууллагуудад албан шаардлага хүргүүлэн, хугацаатай үүрэг даалгавар өгч хугацаа дууссан 5 төрлийн 5 бүтээгдэхүүн буюу 175.0 мян төгрөгийн барааг хураан авч устгал хийгдэв.

Сумын газар тариалан эрхлэгчдийн анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулж тус арга хэмжээнд аймгийн ХХААГ-ын дарга Т.Баатарзориг газар тариалангийн өнөөгийн байдал цаашдын зорилтын талаар илтгэл тавьж нарийн ногооны үр, улаан төмс, эрт ургацын үрийн төмсний үрийн тусламж үзүүлж зөвлөгөөн амжилттай болж өндөрлөв. Сумын дүнгээр төмс 4,8га-д, нарийн ногоо 2,6га-д, хашсан хадлан 1,6га-д, тэжээлийн ургамал 1,1га-д, жимс жимсгэнэ 1,3га-д тариалах дүн мэдээтэй байна.

“Нээлттэй хаалганы” өдөр зохион байгуулах ажлын хүрээнд “Төрийн үйлчилгээ Таны багт” арга хэмжээг Баянхайрхан багт зохион байгуулан ИТХ, ЕБС, Бүжинхэн цэцэрлэг, Хүн эмнэлэг, Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэнүүд, Иргэний бүртгэл, Нийгмийн халамж, нийгмийн даатгал, татвар төлөлт, газрын гэрчилгээ олгох зэрэг зөвлөгөө, мэдээлэл өгөх, хүргэх үйлчилгээг багийн иргэдэд хүргэж ажиллаа.

Иргэний бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны хүрээнд шинээр төрсөн хүүхэд 8, гэрлэлт 1, нас баралт 2, шилжин явсан, шилжин ирсэн, хашаа байшингийн гэрчилгээ шинээр авах 25, 45 насны иргэдийн паспортны сунгалт 24 иргэний хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллав.

Сумын МЭҮТ Коли иж балнадын ийлдэс 3186 толгой малд, Сохор доголын вакцин 38350 толгой малд, Шөвөг ярын вакциныг 34400 толгой малд тарьсан ба мал эмнэлэг халдваргүйжүүлэлтийн аяны хүрээнд “Цагаан дугуйн” цэгийн бөхөнгийн сэг зэмийг шатаан булж устгахад бэлэн болгов.

Монгол мал хөтөлбөрийн хүрээнд Мал аж ахуйн тогтвортой хөгжлийн хөтөлбөр байгаль хамгаалах иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилтыг цогцоор шийдэх арга зам сэдэвт сургалтыг Бэлчээр ашиглагчдын холбоо ТББ-тай хамтран зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 20 гаруй иргэд 5 хоршооны төлөөлөл МЭҮТ-ийн мэргэжилтэнүүд, байгаль хамгаалагчид, татварын байцаагч нар оролцов.

Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд Амьжиргааг дэмжих зөвлөл 2 удаа хуралдсан ба нийт 72 иргэнд халамжийн тэтгэвэр, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 68 иргэнд 4.600.0 мянган төгрөг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжийг 85 иргэнд 3.100.0 мянган төгрөг, ахмад настаны унааны зардал 2 иргэнд 300 000 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний харилцаа холбооны зардал 1 иргэнд 20 000 төгрөгийн тус тус тэтгэмжийг олгов.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас “Халамжаас-хөдөлмөрт” нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж сумын амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүд, багийн Засаг дарга нарт мэдээлэл хийж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдах 4 малчин залууг сонгож, 80 гаруй иргэний санал, хүсэлтийг сонсож, зөвлөгөө өгч үйлчилгээ үзүүлэн ажиллаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 17415.6, иргэний сайн дурын даатгалд 50 иргэнээс 5521.5, эрүүл мэндийн даатгалд 52 иргэнээс 2541.5, нийт 25478.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэв.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэврийн даатгалын санд 80857.1 мянган төрөгийн санхүүжилт авч өндөр насны тэтгэврийг 258 хүнд 69694.6 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 12 хүнд 2767.0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийг 35 хүнд 8133.0 мянган төгрөг, ҮОМШӨ-ний сангаас 1 хүнд 262480 төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг тус тус олголоо.

Эрүүл мэндийн төв нь тайлант сард амбулаторийн үзлэгээр 30 иргэнийг хэвтүүлэн эмчлэв. Сувилахуйн нэг өдрөөр “Эх хүүхдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулъя” уриан дор нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж 40-64 хүртэлх зорилтот бүлгийн иргэдэд чихрийн шижингийн эрт илрүүлгийн үзлэг хийж, Хорьтын айл өрхөөр явж өндөр настан 19, 0-5 хүртэлх насны 13 хүүхэд, жирэмсэн 1 эхэд зөвлөгөө өгч ажиллаа.

Сумын “Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах жилийн ажлын төлөвлөгөөний дагуу аймгийн БОЭТ-ийн хүний гавъяат эмч нар урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ хийж тус үзлэгт дотрын эмчид 85, хүүхдийн эмчид 53, эмэгтэйчүүдийн эмчид 40, ЭХО-д 106, чих хамар хоолойн эмчид 76, мэдрэлийн эмчид 77 нийт 437 иргэнд эрүүл мэндийн үзлэг шинжилгээ хийж иргэдийг бүрэн хамруулсан үр бүтээлтэй ажил боллоо.

Бүжинхэн хүүхдийн цэцэрлэг нь сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг хэвийн явуулж ажилласан ба гэр цэцэрлэгийг тоног төхөөрөмжөөр хангахаар БСШУЯ-аас цагаан хэрэглэл, коршик, 12 волтоор ажилладаг хөргөгч, 1,2 дугаар хоолны таваг, халбага сэрээ, бусад тоног төхөөрөмж, тоглоом зэргийг ажлын хэсэг хүлээн авч бүртгэв.

Сумын 12 жилийн бүрэн дунд сургууль нэгдүгээр ангийн сурагчдын “Эрдмийн баяр”-ыг тэмдэглэн тайлант уншлагын нэг өдөр зохион байгуулж, 47 сурагчид сурч мэдсэн зүйлээ тайлагналаа.

2017 оны жилийн үйл ажиллагаанд төлөвлөгөөнд тусгагдсан графикт ажлын хүрээнд дотуур байрын сурагчдад амьдрах ухаанд суралцахад дараах сургалтуудыг зохион байгуулж ажилласан. Үүнд: гоёл чимэглэл, сураар чөдөр ногт зангидах, дээл эсгэх, утас ээрэх, эсгийгээр аяганы ширмэл уут хийх, товч зангидах, шилбэ хадах гэх мэт.

Эрдэнэбүрэн сум: “Сумын Засаг даргын ажлын 100 хоног”-т хийсэн ажлын талаар сонин гаргаж 700 хувь хэвлэн сумын нийт өрхөд хүргэн тайлангаа тавьж цаашдын зорилтоо тодорхойллоо.

”Хууль журам-миний амьдралд” аяны хүрээнд аяны дарцаг, дэвтрийг аялуулж баг, байгууллагууд хууль сурталчлах, сургалт зохион байгуулах ажлыг хийж хийсэн ажлаа иргэдэд тайлагнав.

Монгол улсын ХНХЯ-ны захиалгаар улс орон даяар хийгдэж буй “Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг суманд амжилттай зохион байгуулж 415 өрх хамрагдлаа.

Сумын “Залуучуудын чуулга уулзалт”-ыг 2017 оны 05 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд соён гэгээрүүлэх лекц, эрүүл мэндийн үзлэг, урлаг, спортын уралдаан, тэмцээнийг зохион байгуулж 125 гаруй залуусын төлөөлөл оролцлоо.

Австри, Монголын эрдэмтдийн хамтарсан баг “Ямаан сүрэгт үржлийн ажлыг шинэ хөтөлбөрөөр явуулах төсөл”-ийн 1 дүгээр шатыг суманд хэрэгжүүлж, 50 гаруй малчдаас судалгаа авч, мал аж ахуйн баг бүрээс түүврийн аргаар 12 айлын 101 эм ямаа, 52 ухна-д хэмжилт хийж ноолуурын дээж авав.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэн “Үндэсний мод тарих өдөр”-өөр сумын төв гудамж, цэцэрлэгт хүрээлэн, баяр наадмын стадионд 1000 хайлаас, 800 улиас, 200 бургас нийт 2000 мод тарилаа. Албан байгууллагууд 100 мод тарьж сумын дүнгээр 2100 мод тарилаа.

Ахмад эмч нарын холбооны эмч нарын үзлэг зохион байгуулж давхардсан тоогоор 400 гаруй иргэд үзлэгт хамрагдаа.

”Эрдэнэбүрэн-2017” төгсөгчдийн спортын наадмыг аймгийн нутгийн зөвлөл, төгсөгчдийн холбоотой хамтран аймгийн төвд зохион байгуулж нийт 42 багийн 500 гаруй төгсөгчид оролцож гар бөмбөг, олс таталт, теннис, буухиа гэсэн 4 төрлөөр өрсөлдлөө.

”Сумын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн”-ийг сар бүрийн 25-ны өдөр хийж хэвшсэн ба энэ удаагийн зөвлөгөөнөөр сумын Соёлын төвийн мэдээллийг хэлэлцэв.

БСШУЯ-ны дэргэдэх боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн Х.Оюунбилэгийг урьж сумын ЕБС-ийн үйл ажиллагаанд үнэлгээ хийлгэж арга зүйн зөвлөгөө авч ажиллаа.

Кенгуру олон улсын математикийн олимпиадад 46 сурагч оролцож алтан медаль 5, мөнгөн медаль 2, хүрэл медаль 1, 2 дугаар зэргийн диплом 8, 3-р зэргийн диплом 4 сурагч тус тус хүртэж, нийт 20 сурагч амжилттай оролцлоо.

Сумын хэмжээнд Нийтийн цэвэрлэгээний ажил зохион байгууж бүх төрийн байгууллагуудын 66 төрийн албан хаагчид оролцож 300га талбайн хог, хаягдлыг цэвэрлэж хогийг хогийн төвлөрсөн цэгт буулгалаа.

Мөнххайрхан сум: Аймгийн засаг даргын захирамжаар зохион байгуулагдсан ээлжит цэрэг татлагаар үзлэгт орж тэнцсэн 5 иргэнийг 2017 оны 05 сарын 01-нээс 05 сарын 03-ны өдрүүдэд Ховд аймагт ЗДТГ-ын дарга өөрийн биеэр аваачиж, анги салбаруудад хуваарилалт хийж, хүлээлгэн өгч, ээлжит цэрэг татлагаар халагдсан 4 иргэнийг хүлээн авч ажилласан байна.

Сумаас Баасан гараг бүрийг бүтээлч ажлын өдөр болгож зарласантай уялдуулан 2017 оны 05 сарын 04, 12, 19, 26 өдрүүдэд бүтээлч ажлаар сумын төвийн стадион болон байгууллагуудын гадна талбайд мод тарих, гудамж талбай болон Сэнхэрийн гол дагуух хог хаягдлыг цэвэрлэх, цэцэрлэгт хүрээлэн байгуулах зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг зохион байгуулж, сумын албан хаагчид, иргэдийг бүрэн хамрууллаа. Дээрх ажилд сумын хэмжээнд цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа 8 иргэнийг зарлан дуудаж оролцуулан 10 хоногийн дадлага, сургуулилт, бүтээн байгуулалтын ажилд хамрууллаа.

Аймгийн ЗДТГ-ын хэлтэс, газар, тасгаас зохион байгуулсан 4 удаагийн сургалт, зөвлөгөөнд холбогдох албан тушаалтан иргэдийг цаг хугацаанд нь бүрэн хамруулж оролцуулав.

Мөн 2017 оны 05 сарын 15, 16-ны өдрүүдэд аймагт зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанд ажилласан тайлан, уулзалтын арга хэмжээнд сумын ИТХ-ын дарга, Засаг дарга болон 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцов.

Сумын 90 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд ажлын хэсгүүдийн хурлыг зохион байгуулж ойн хандив төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Ойн түүхэн номын эхийг бэлтгэх ажлаар тус сумын уугуул болон тус суманд ажиллаж амьдарч байсан 34 хүнтэй утсаар холбогдож, 64 хүний холбогдох материал, зургийг хүлээн авч нэгтгэн номыг хэвлэлтэнд өгөх ажлыг бэлэн болголоо.

Сумын Засаг даргын зүгээс өгсөн үүрэг чиглэлийн дагуу багуудын ИНХурлыг хуралдуулж хаваржааны бүс нутаг чөлөөлөх, зуслангийн бүс нутаг тогтоох асуудлаар шийдвэр гаргуулан хэрэгжүүлж эхлээд байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу сонгуулийн хороо байгуулагдан сонгуулийн бэлтгэл ажлуудыг ханган ажиллаж байна.

Төрийн хууль, тогтоомж шийдвэр сурталчлах ажлын хүрээнд эрх зүйн ажлын болон иргэний танхимын хэлэлцүүлэг, сургалт сурталчилгааны төлөвлөгөөнд заагдсаны дагуу ажилтнуудад мэдэгдэж, Газрын ажилтнуудын өдрийг угтаж газрын тухай хууль, Газар өмчлүүлэх тухай хууль, сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний талаар албан байгууллагуудаар сургалт хийж, 51 хүнийг хамруулж, ганцаарчлан болон хэсэгчлэн уулзалт хийж, зөвлөгөө өгч ажиллав.

Мөн энэ сарын 17-ны өдөр Архив албан хэрэг хөтлөлт, дотоод ажлын талаар Архив, бичиг хэргийн эрхлэгч Д.Тунгалаг, Эрх зүйн ажилтан Ц.Тунгалаг нар баталсан удирдамжийн дагуу хамтран Тамгын газрын ажилтнууд, багийн Засаг дарга нарт сургалт хийв.

2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр тус ОУ-ын төслийн НТС байгууллагын төв офисын ажилтан Т.Ганхуяг, баруун бүсийн зөвлөх Д.Цэвээнравдан, аймгийн Байгаль орчны газрын мэргэжилтэн Н.Цэен-ойдов нар баруун бүсийн аймгуудын экологийн чухал ач холбогдолтой бүс нутаг, түүнийг тусгай хамгаалалтанд авах талаар болон өөрчлөлтийн онол, байгальд ээлтэй сэтгэлтнүүдийн сургалт зохион байгуулав. Тус сургалтанд албан байгууллагын ажилтнууд, байгаль хамгаалах нөхөрлөлийн төлөөлөл, эко клубын сурагчид оролцов.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Л.Билэгдэмбэрэлээр ахлуулсан ажлын хэсэг 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдөр ажилласан бөгөөд “Халамжаас - Хөдөлмөрт” нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж нийт 89 иргэнд мэдээлэл хүргэж үйл ажиллагаагаа сурталчилж ажиллаа.

Ажиллах хугацаандаа 2016 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн биелэлт, 2017 онд хэрэгжүүлэхээр шалгаруулсан төслүүдийн хэрэгжилттэй танилцаж зөвлөгөө чиглэл өгч, сумын удирдлагуудтай ажил төрлийн уулзалт хийж ажилласан байна.

Энэ сард Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 3 удаа зохион байгуулж, хүнсний эрхийн бичгээр үйлчилж буй “Их хунт” аж ахуйн нэгжийн хүнсний дэлгүүрт хийсэн хяналт үнэлгээний талаарх мэдээллийг танилцуулахын зэрэгцээ малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Алаг багийн малчин Балдаагийн Баярлах, Балданжавын Пүрэвбадь, Борт багийн малчин Сурахбаярын Энхжаргал нарын асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлээ.

Мөн хурлаар өвчний учир байнгын асаргаа шаардлагатай Мандахбаярын Адъяаг асаргаанд оруулах, Сэнхэр багийн иргэн Б.Жамъянбазарыг асарч буй И.Бадрахын асаргааг өөрчилж, Б.Байгальд эрхийг шилжүүлэх өндөр настны тэтгэвэрт гарахад Нийгмийн даатгалаас тэтгэвэр авах эрх үүсээгүй Ноосонгийн Уртнасанг тэтгэвэрт хамруулах зэрэг асуудлуудыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэв.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд Г.Байгалмаа ахлагчтай "Ахан дүүс" бүлгийн Хамтын хөдөлмөр, Нийтийн хүртээл төсөл шалгарч баримт бичгийг ХХҮГ-т хүргүүллээ.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд бүлгээр хүнсний ногоо тариалахаар Т.Амгалан ахлагчтай 6 өрх хамтарч Алагийн аманд ногоо тариалахаар газар хагалан, үр суулгах ажлыг эхлүүлээд байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч буй 12 өрхийн иргэдийг сумын суваг шуудуу янзлах, зам засах зэрэг бүтээлч ажилд татан оролцууллаа. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүй 15 иргэнийг LMIS програмд бүртгэсэн байна.

Нийгмийн халамжийн хөнгөлөлт, тусламж хүссэн 8 иргэний өргөдөл болон холбогдох материалыг хүлээн авч шийдвэрлэлээ.

Сумын хяналт шалгалтын ажлын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Хүнс худалдаалдаг, үйлчилдэг цэгүүдэд 05 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд сумын Хүнсний аюулгүй байдал хариуцсан байцаагч, олон нийтийн байцаагч, сумын нийгмийн ажилтаны бүрэлдэхүүнтэй ажиллаж, 11 аж ахуй нэгж дэлгүүрт хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, цаашид анхаарах асуудлын талаар мөн тамхины хяналтын хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар зөвлөмж өгч ажиллав.

Алаг багийн чиглэлд Сумын засаг дарга болон Сумын МЭҮТ-ийн мэргэжилтэн В.Батчулуун, “Царцаа хоршоо” МЭҮН-ийн эмч Р.Бямбадорж, Алаг багийн хүний эмч А.Хандсүрэн нарын бүрэлдэхүүнтэйгээр явж мал хаваржилт, сумын 90 жилийн ой угтсан ажил болон цаг үеийн ажлаар иргэдтэй уулзаж, тэдний санал хүсэлтийг сонсож, зөвлөлдөн 40 гаруй өрхөөр орж 2 өдөр ажиллаа.

Алаг Борт багт төвлөрүүлэн маллаж байгаа хээлтүүлэгчийн онд оролт хаваржилтын талаар мэдээ авахад 2 суурьт ялган суурилсан 685 толгой хуц ухна 96 хувиар онд орсон байна.

Сумын МЭҮТ-ийн зүгээс малчидтай гурвалсан гэрээ байгуулах, үзлэг шинжилгээ, ангилалтанд хамрагдуулах ажлыг эхлүүлээд байна.

УБ хотод зохион байгуулагдаж байгаа Аварга малчдын зөвөлгөөнд Борт багийн малчин О.Чойжилжав, Хаг багийн малчин Оюун нарыг оролцуулж, ажлын үзүүлэлт, туршлагын талаарх анкет, тодорхойлолт хийж аймгийн ХХААГ-аар дамжуулан холбогдох байгууллагад уламжлав.

Тайлант сард МЭҮТ-аас том малын зүй бус хорогдол, төл бойжилт, хээл хаялт, сувайралтын 4 удаагийн мэдээ явуулснаас 5 сарын 25-ны байдлаар гарсан төлийн 99 хувь нь бойжиж, бог малын 60 хувь, бод малын 87 хувь нь төллөсөн, том малын зүй бус хорогдол нийт малын 0,2 хувийг эзэлж, хээл хаялт сувайралт 10 гаруй хувьтай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар бүх нийтээр мод тарих өдрийн арга хэмжээнд сумын нийт байгууллага, аж ахуйн нэгжүүд, иргэд идэвхтэй оролцож нийтдээ 2150ш суулгацыг шинээр суулгаж, ургаж байгаа моднуудыг услах, тордох ажлыг бүх нийтээр идэвхтэй зохион байгуулж тайланг хугацаанд нь хүргүүлж ажиллаа.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын хүрээнд Сэнхэрийн гол, түүний ай сав дагуух газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдөр сумын Засаг даргын баталсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэв.

Дээрх ажилд Ерөнхий боловсролын сургуулийн 10 ангийн /2а, 2б, 3а, 3б, 4а, 6а, 7а, 8а, 10а, 11а/ 260 сурагч идэвхитэй оролцож нийт 2тн хог хаягдлыг нэгдсэн цэгт хүргэж, уурын зуух, хуучин Засаг даргын Тамгын газрын ар талын зүлэг, наадмаар гэр барих газарт очих зам дагуух хайрга, чулууг түүх зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ. Ажилд оролцсон анги тус бүрийг багш, мэргэжилтнүүд хариуцан хамтран ажилласан болно.

Цаашид Сэнхэрийн гол дагуух хогийн савны тоог нэмэгдүүлэх олноор байрлуулах, хурсан хог хаягдлыг тогтмол ачиж, цэвэрлэж байх нь зүйтэй гэсэн шийдвэр гаргаж, хяналтыг сайжруулахаар төлөвлөөд байна.

Ус цаг уур орчны шинжилгээний Мөнххайрхан өртөөнөөс цаг уурын шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу хийж цаг агаарын мэдээг хоногт 8 удаа, сард 240 удаа, 10 хоногийн агро мэдээг 3 удаа, хоногийн мэдээг 22 удаа, сарын төлөв мэдээг 1 удаа, сэрэмжлүүлэг мэдээг 1 удаа, 7 хоногийн тойм мэдээг 5 удаа, 5 хоногийн мэдээг 4 удаа, аюулын агаар мэдээг тус бүр 1 удаа тус тус сумын Засаг дарга, Тамгын газарт танилцууллаа.

Энэ сард 12.2мм тунадас орсон. Хамгийн их хүйтэн 5 дугаар сарын 4-нд агаарт 13,2 °С, хөрсөнд 13.0°С хэмийн хүйтэн, хамгийн дулаан 5 дугаар сарын 15-нд агаарт 23.6°С, хөрсөнд 5 дугаар сарын 23-нд 48.5°С хэмийн дулаан байсан. Усны 2 техникч өнгөрөлтийн мэдээг сард 120 удаа, үйлчилгээний мэдээг төвд 60 удаагийн мэдээг дамжуулж ажиллав.

Орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэгээр 22404.5 мян/төг, орон нутгаас төсөвт төвлөрөх орлогоор 1479.9 мян/төг орж бүгд 23884.4 мян/төг болж үүнээс ИТХ-д 3160.2 мян/төг, ЗДТГ-т 20724.2 мян/төг-ийг тус тус санхүүжилтэнд олголоо.

Үүнд: Орон нутгийн хөгжлийн санд санхүүжилтээр 5000.0 мян/төг ирснээс МЭУСАХ-ний санхүүжилтэнд 4100.0 мян/төг-ийг 2 мал эмнэлэгт хувиарлан олгож, үлдсэн 900.0 мян/төг-ийг төлөвлөгдсөн бүтээн байгуулалтын ажилд зарцуулж байна.

Сумын 90 жилийн ой угтсан бүтээн байгуулалтын ажилд зориулан аймгийн Засаг даргын эрх шилжүүлэлтээр 8000.0 мян/төг ирснийг тус сумын төвд байгуулж буй “Цэцэрлэгт хүрээлэн”-гийн хашаа худалдан авах, тээвэрлэж ирэх, явган замын хавтан,

цемент худалдан авах, тээвэрлэж ирэх зэрэг үйл ажиллагаануудад зарцууллаа. Гудамж төслийн хүрээнд хийгдэх ажил материалаа татаж ажлаа эхлүүлээд байна

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтээр нийт 87979.5 мян/төг ирснийг 12 жилийн сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагуудад хуваарийн дагуу санхүүжилт олгож зарлагын гүйлгээнүүдийг хийв. Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүгийн үйл ажиллагаанууд хэвийн явагдаж өр авлага үүсээгүй байна.

ИТХ-ын цалингийн сан хүрэлцэхгүй байгаагаас оны эхнээс сар бүр 100.0 мянга гаруй дутагдаж хуримтлагдсаар байгаад одоогийн байдлаар 550.0 гаруй мянган төгрөгийн өр үүсээд байна.

НӨАТ төлөгч 5 ААНБ-ын 4 дүгээр сарын НӨАТ-ын тайланг хугацаанд нь гаргуулж илгээсэн. Орон нутгийн орлого 9 нэр төрөлд 8453,0 мянган төгрөг өссөн дүнгээр 4586,5 мянган төгрөг төвлөрч 56% ийн биелэлттэй байна.

Аймгийн төвлөрсөн орлого 4 нэр төрөлд 43131,2 мянган төгрөг төвлөрүүлэхээс 42620,8 мянган төгрөг төвлөрүүлж 98,8%-ийн биелэлттэй. Улсын төвлөрсөн орлого өссөн дүнгээр 3 нэр төрөлд нийт 1477,7 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1448,5 мянган төгрөг төвлөрүүлж 98%-ийн биелэлттэй байна. Нийт 53061,9 мянган төгрөгийн орлого төсөвт оруулахаас 48655,8 мянган төгрөг төвлөрүүлж 91,6% ийн биелэлттэй байна. Орон нутгийн орлого тасарч байгаа шалтгаан нь иргэдийн ноосны урамшуулалын 10%-ын татвар төрийн сангаас орж ирээгүй, мөн улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ буурсантай холбоотой юм.

2017оны 05 дугаар сарын 13-14 өдрүүдэд АТӨЯХ-ийн улсын үзлэг явагдаж ба нийт 113 тээврийн хэрэгслийг улсын үзлэгт хамруулж, 5265,7 төгрөгийн албан татвар, 566500 төгрөгийн агаарын бохирдлын төлбөрийг төсөвт төвлөрүүллээ. Тус үзлэгийн үеэр 12 тээврийн хэрэгслийн өмчлөл өөрчилж өөр аймаг хотын дугаартай 4 тээврийн хэрэгсэл ХО дугаар авсан ба ашиглах боломжгүй болсон 7 тээврийн хэрэгслийн материалыг бүрдүүлж, ашиглалтаас хасуулахаар холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өглөө.

Мөн 05 дугаар сарын 18-ны өдөр Татвар төлөгчдийн анхдугаар чуулга уулзалт Ховд аймагт зохион байгуулагдаж, нийт 17 сумын 105 татвар төлөгч тус уулзалтанд оролцсон ба тус сумаас ЗДТГ-ын татварын байцаагч болон “Алагийн буурал” хоршооны захирал Б.Чинбат, хувираа бизнес эрхлэгч Ч.Янжин, “Цэнхэрийн долгио” ХХК-ийн ня-бо Б.Батцэнгэл, “Цэнхэрийн тулга” хоршоог төлөөлөн С.Ганболд, “Жамъяангарав оргил” хоршооны гишүүн А.Бямбасүрэн нарын бүрэлдэхүүнтэй оролцсон байна.

2016-2017 оны хичээлийн жилд Мөнххайрхан сумын сургуулийг нийт 40 сурагч төгсөж 2017.05.01-ны өдөр мөнгөн хонхны баяраа хийлээ. Баярын үеэр сурч боловсрох хугацаандаа бусдыгаа манлайлсан шилдэг сурагч, багш нараа шагнаж урамшууллаа. Эрдмийн баярын үйл ажиллагаанд сумын удирдлагууд, эцэг эхчүүд, сургуулийн сурагчид оролцлоо.

Тус сургууль дээр олон нийтийн оролцоот сургууль төсөл хэрэгжээд багагүй хугацаа өнгөрөөд байгаа билээ. Энэхүү төслийн хүрээнд Жаргалант сумын 7-р сургуулийн хэрэгжилтийн баг 2017.05.05-ны өдөр тус сургууль дээр ирж төслийн үйл ажиллагаатай танилцлаа. Мөн Мөнххайрхан сумын төслийн баг 2017.05.02-ны өдөр Мянгад сумын сургуулийн төслийн үйл ажиллагаатай танилцаад ирлээ.

Англи хэлний үсэглэлийн баяр 2017.05.03-ны өдөр, 1-р ангид элсэн орсон бяцхан сурагчид 35 үсгээ нүдэлж уншиж сурсны баяр болох цагаан толгойн баяраа 2017.05.05-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Мөн “Инээмсэглэл бэлэглэл” уриан дор өдөрлөг зохион байгуулж шог зураг, хөгжилтэй бичлэг, онигоо, төрөл бүрийн хөгжөөнт тэмцээнүүд 2017.05.05-ны өдөр зохион байгуулагдан хүүхэд бүр зураг, бичлэг, авхаалж самбаа хэл яриагаараа уралдаж нэг

өдрийг инээмсэглэл дүүрэн өнгөрөөлөө. Уралдаанд бүтээлээ ирүүлсэн сурагчид эцэг эх, гэр бүл, найз нөхдийн инээд наргиа, тоглоом улс төр, спортын алдартан олон сэдвээр зургаа зурсан байна. Уралдаанд ирсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж сургуулийн коридорт байрлууллаа.

Үндэсний хэмжээнд бага, суурь, бүрэн дунд боловсролын төгсөх ангийн суралцагчдын мэдлэг, чадварын түвшинг үнэлэх улсын шалгалтууд тус сургууль дээр 5-р сарын 22-30-ны өдрүүдэд явагдаж байна.

Багш ажилчид түүхт сумынхаа 90 жилийн ойд зориулан сургуулиа гэрэлтдэг хаягтай болгох, бүтээлч ажлын хүрээнд сумын Улаан говийн хөтөл дээр үдэлт угталтын хаалга хийх, бүтээн байгуулах ажилдаа ороод байна. Нийтээр мод тарих өдөр сургуулийн сааданд 100 гаруй мод тарив.

Багш нар хөгжүүлэх үйл ажиллагааг сар, 7 хоногоор төлөвлөж, аргачлал боловсруулж ажилласан бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу МУГЖ Б.Дугараагийн нэрэмжит “Алтан өв” наадамд хамтлаг, гоцлол төрлөөр 8 хүүхэд бэлтгэж амжилттай оролцлоо.

Цэцэрлэгийн хүүхдийг зонхилон тохиолдох эмгэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлааг сайжруулах, витамин дутагдал нөхөх зорилгоор “Амин дэм-2 аян”-ыг зохион байгуулж, аяны хүрээнд хүүхдийн хоол тэжээлийн амин дэмийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн витаминлаг хоол тэжээлээр хүүхдийг хангах ажлуудыг хийж хэрэгжүүлж байна.

Олон улсын хүүхдийн эрхийн өдөр, Эх үрсийн баярыг угтан цэцэрлэгийн хүүхдийн “Жаргалтай хүүхэд нас” тайлан тоглолт тавьж олны хүртээл болголоо.

“Нэг хүүхэд нэг цэцэг аян”-ыг зохион байгуулж аяны хүрээнд эцэг эхчүүдээр цэцгийн сав бэлдүүлж түүнд хүүхдүүд эцэг эхтэйгээ хамтран цэцэг тарьж ургууллаа.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3, 3.1.6 дахь зорилтод тусгасан “Элэг бүтэн-Монгол”, “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2017 оны 05 дугаар сарын 10-20-ны өдрүүдэд “Хепатит В вирүсийн халдвараас сэргийлье” уриан дор элэгний в, с вирусын шинжилгээг Мөнххайрхан сумын 40-65 насны иргэдэд хийж эрүүл гарсан иргэдийг В вирүсийн эсрэг вакцинаар дархлаажуулах ажлыг амжилттай зохион байгуулсан. Шинжилгээнд нийт 290 хүнийг хамруулж, В вирүсийн вакцинаар нийт 140 хүнийг эхний тунгаар дархлаажуулалтанд хамрууллаа.

Мөн уг арав хоногийн хугацаанд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 16, 17 настай сурагчдыг улаанбурхан, улаанууд өвчний эсрэг хавсарсан вакцинаар дархлаажуулж 16 настай 25 сурагч, 17 настай 30 сурагч нийт 55 сурагчийг 100 хувийн хамралтаар дархлаажуулав.

Гэрийн эргэлтээр 5 сарын 11-нд Хаг багийн Долооннуур, Гарлага, Их хаг, Хүрэн асга, Шалбарт зэрэг газруудаар Эх баригч Б.Сэргэлэн, Багийн эмч С.Чимэдрэгзэн, Лаборант Б.Батсайхан, Вакцинатор Я.Сувд-Эрдэнэ, Жолооч С.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй явж нийт 65 хүнийг /эх, нярай, артерийн гипертензия/ үзэж, 21 хүнд элэгний В, С илрүүлэх шинжилгээ хийж, 14 хүнд В вирүсийн эсрэг вакцинаар дархлаажуулсан.

2 дахь удаагийн ээлжийн эргэлтээр 5 сарын 15-нд Борт багийн Баянсай, Их тошин чиглэлд их эмч Б.Батзориг, эх баригч эмч Б.Сэргэлэн, Лаборант бага эмч Б.Батсайхан, вакцинаатор Я.Сувдэрдэнэ, багийн эмч О.Буяннэмэх, жолооч С.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй явж нийт 80 хүнд /артерийн гипертензия болон хүүхэд эхчүүд/ үзлэг хийж, 24 хүнд элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээ хийж, 19 хүнийг В вирусын вакцинаар дархлаажуулав.

3 дахь ээлжийн эргэлтээр Сэнхэр багийн Ендэрт , Улаан хашаа, Цагаан эрэг, Гурван өтгийн чиглэлд Эх баригч эмч Б.Сэргэлэн, багийн эмч Р.Мандахбаяр, Вакцинатор Я.Сувдэрдэнэ, жолооч А.Төртогтох нарын бүрэлдэхүүн ажиллаж, нийт 32 хүнд үзлэг хийж, 14 хүнд элэгний В,С вирусын шинжилгээ хийж, 11 хүнийг дархлаажуулалтанд хамруулав.

Алаг багийн чиглэлд 5 сарын 16-ны өдөр Их эмч Б.Батзориг, Багийн эмч А.Хандсүрэн, Лаборант Б.Батсайхан, Жолооч С.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэйгээр явж нийт 33 өрхийн 92 хүнд үзлэг хийж, 42 хүнд элэгний В, С вирусын шинжилгээ хийж, 14 хүнд В вирусийн вакцинаар дархлаажуулав.

В, С вирусийн шинжилгээг: Хөдөөгийн багт нийт 101, суманд 189 хүнд хийсэн байна. В вирусийн вакциныг: Хөдөөгийн багт нийт 58 хүнд, суманд 82 хүнд хийгдсэн байна. Мөн гэрийн эргэлтээр явахад элэгний В, С вирус, “Давсгүй-цай” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулж ажилласан.

Эрүүл мэндийн төвийн 24 ажилчин, сургуулийн эмч, эмийн санчид 5 сарын 09-ны өдөр сүрьеэгийн туберкулины сорил тавьж хариуг нь эрүүл мэндийн газарт хүргүүлсэн. Булган суманд “Яаралтай тусламжийн цогц менежмент” сэдэвт сургалтанд Эрхлэгч эмч Д.Энхбулган, Их эмч Б.Батзориг, Бага эмч О.Буяннэмэх, Сувилагч М.Жаргалмаа, Ч.Эрдэнэчимэг нар 2017 оны 05 сарын 4-5-ны өдрүүдэд хамрагдаж 2 багц цаг бүрдүүлэв.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР